



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН
Т У Ш А А Л

2013 оны 10 дугаар
сарын 31-ны өдөр

Дугаар 91

Улаанбаатар хот

Үйл ажиллагааны үндэсний
Төлөвлөгөө батлах тухай

“Нээлттэй засгийн түншлэлийн тухай” Засгийн газрын 2013 оны 381 дүгээр тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө-IV”-г хавсралт ёсоор баталсугай.
2. Батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, Монгол Улсын Нээлттэй засгийн түншлэлийн Үндэсний зөвлөлд танилцуулахыг Үндэсний зөвлөлийн дэд дарга (У.Бямбасүрэн)-д даалгасугай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга




Ц.НЯМДОРЖ

000021200362

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2021 оны 12...дүгээр сарын 31...
өдрийн 91 дугаар тушаалын хавсралт



НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV

2021-2023

МОНГОЛ УЛС

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

ТОВЧИЛСОН ҮГСНИЙ ЖАГСААЛТ

НЗТ:- Нээлттэй засгийн түншлэл
ҮАҮТ: Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө
ЗГХЭГ: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ИНБ: Иргэний нийгмийн байгууллага
ЭМЯ: Эрүүл мэндийн яам
БШУЯ: Боловсрол, шинжлэх ухаан яам
ТББ: Төрийн бус байгууллага
ОУБ: Олон Улсын байгууллага
ТЕГ: Татварын ерөнхий газар
ААНБ: Аж ахуйн нэгж байгууллага
НӨАТ: Нэмүү өртөгт албан татвар
ХААГ: Худалдан авах ажиллагааны газар
МҮХАҮТ: Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
МҮОНРТ: Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз
ТӨК: Төрийн өмчит компани
ТУЗ: Төлөөлөн удирдах зөвлөл
АТГ: Авлигатай тэмцэх газар

ТАНИЛЦУУЛГА: НЗТ-ИЙН ҮЙЛ ЯВЦАД МОНГОЛ УЛСЫН ОРОЛЦОО

Монгол Улсын Засгийн газар засаглалыг бэхжүүлэх зорилтын хүрээнд төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангах, төрийн болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд иргэд, олон нийтээс гаргаж буй санал, санаачлагыг харгалзах замаар тэдний оролцоог нэмэгдүүлэх, авлигаас ангид байх, төрийн үйлчилгээнд шинэ дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх зорилгоор дэлхийн улс орнуудын сайн дурын олон талт санаачлага болох Нээлттэй Засгийн Түншлэл (НЗТ)-д 2013 онд нэгдэн орсон билээ. НЗТ-ийн гишүүн орны хувьд Монгол Улсын Засгийн газар төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангах, иргэдийн оролцоо, инновацийг дэмжсэн, эрүүл, аюулгүй нийгмийг бүрдүүлэхэд чиглэсэн байх зарчмыг хэвшүүлэх тодорхой зорилт тавин ажиллаж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (ЗГХЭГ) нь Монгол Улсын НЗТ-ийн асуудлыг хариуцан ажилладаг. НЗТ-д оролцсон эхний үе шатанд Гадаад харилцааны яам энэхүү үүргийг хүлээж байсан бол 2013 оны 6 дугаар сараас эхлэн ЗГХЭГ хариуцах болсон юм. Монгол Улсын Ерөнхий сайдын 2015 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 207 дугаар захирамжаар 2014 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 61 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралтыг өөрчлөн найруулсан.

Үндэсний Зөвлөл нь бүтцийн хувьд яамд, орон нутаг, иргэний нийгмийн байгууллагууд гэсэн гурван салбараас бүрддэг. Үндэсний зөвлөлийг ЗГХЭГ-ийн дарга ахалдаг бөгөөд гишүүдэд ЗГХЭГ-ын дэд дарга, Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яамны төлөөлөл багтдаг. Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн даргаар ЗГХЭГ-ийн Хяналт, шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга ажилладаг. Иргэний нийгмийн бүрэлдэхүүнд Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим (МҮХҮАТ), Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо (МАОЭНХ), Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо (МҮЭХ) болон Нээлттэй нийгэм форум багтсан.

НЗТ-ийн гишүүн орон нь Засгийг нээлттэй болгоход чиглэсэн тодорхой арга хэмжээнүүдийг тусгасан Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө (ҮАҮТ)-г НЗТ-ийн

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

Оролцоо ба Хамтын бүтээлийн стандартын дагуу боловсруулан хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Загийн газар дараах гурван төлөвлөгөөг хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө I - 2014-2016 он

Монгол Улсын НЗТ-ийн 2014-2016 оны анхны ҮАҮТ-нд 3 чиглэлийн 35 зорилт, арга хэмжээг тусган хэрэгжүүлж ажилласан. Тус төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад буюу 2015 онд ЗГХЭГ-аас “Дунд хугацааны өөрийн үнэлгээний тайлан” болон НЗТ-ийн хөндлөнгийн шинжээчдийн “Хараат бус тайлан” гарсан бөгөөд хөндлөнгийн шинжээчдийн үнэлгээгээр Байгаль орчны мэдээллийг ил тод болгох, Төсвийн ил тод байдлыг хангах, Засгийн газрын үйл ажиллагааны талаар 11-11 төвд олон нийтээс ирсэн санал гомдолд хариу мэдээлэх системийг бий болгох гурван зорилт НЗТ-ийн “Од” үнэлгээг авч олон улсын түвшинд сайн жишиг болж үнэлэгдсэн.

2. Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө II - 2016-2018 он

Монгол Улсын НЗТ-ийн 2016-2018 оны II дахь ҮАҮТ нь 13 зорилтот үйл ажиллагаа бүхий үүрэг амлалтыг агуулсан бөгөөд эдгээр 13 үүрэг амлалт нь төрийн байгууллага, иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, хувийн хэвшлийн төлөөллийн оролцоо бүхий хэлэлцүүлгүүдээс дэвшүүлсэн чиглэл, тулгамдаж буй асуудал, түүнийг шийдэх арга зам, үйл ажиллагааны саналд үндэслэн боловсруулж хэрэгжсэн билээ.

3. Үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө III – 2018-2020/2019-2021 он

- Монгол Улсын НЗТ-ийн 2018-2020 оны III дахь ҮАҮТ-г боловсруулах явцад иргэний нийгмийн байгууллагууд идэвх санаачлага гаргаж, төр, иргэд, иргэний нийгэм, хувийн хэвшил, олон улсын байгууллага, хэвлэл мэдээллийн оролцоотой хэлэлцэн санал авснаар 13 зорилтыг дэвшүүлж ажиллалаа.

МОНГОЛ УЛСЫН НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ХҮЧИН ЧАРМАЙЛТУУД

1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх ҮЙЛ АЖИЛЛАГАА:
- 5.2.15.Иргэний нийгмийн байгууллагууд бие даан хөгжих эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
 - 5.2.17.Цахим ардчиллыг хөгжүүлж, төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэд саналаа өгөх, хяналт тавих зэргээр цахимаар оролцох тэгш боломжийг бүрдүүлнэ.
 - 5.3.13.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, иргэдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэхэд мэдээлэл, харилцаа холбооны дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн оролцоог дэмжиж хэрэгжүүлнэ.
 - 5.4.15.Төрийн үйлчилгээг иргэдийн хэрэгцээнд суурилсан, түргэн шуурхай, уян хатан, хүртээмжтэй, чанартай хүргэх иргэн төвтэй төрийн үйлчилгээний стандарт боловсруулж, нэвтрүүлнэ.
 - 5.5.1.Хүний эрхийг хамгаалахад төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжих, хамтран ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлж, хөгжүүлнэ.
 - 5.5.5.Хүний эрхийг хангахад төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжиж хамтран ажиллана
 - 5.5.7.Засаглалын үйл ажиллагаанд иргэд эрх тэгш оролцон үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх боломж, чадавхыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх орчныг бүрдүүлнэ.
 - 5.5.8.Нийгмийн бүлгүүд засаглалын үйл явцад тэгш оролцох боломжийг хангасан тогтолцоог бүрдүүлнэ.
 - 5.5.9.Хэвлэлийн эрх чөлөөг бүх талаар хангаж, ёс зүйтэй, мэргэшсэн сэтгүүл зүйг хөгжүүлнэ.
 - 5.6.3.Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг хангах, хяналт тавих зохицуулалтыг боловсронгуй болгоно.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

- 5.6.8.Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж авлига үүсэх эрсдэлийг бууруулна.

2. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР:

- 3.1.12.Төсөв, санхүүгийн нэгдсэн цахим систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, үр ашигтай болгож, гадаадын зээл, тусламж, төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулах нөхцөл бүрдүүлнэ.
- 4.1.8.Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана.
- 6.2.6.Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, тус сангийн үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх, ил тод байдлыг сайжруулах, олон нийт оролцох, мэдээлэл хүргэх дэвшилтэт арга хэлбэрийг нэвтрүүлнэ.

3. Монгол Улсын Засгийн газрын АВЛИГЫН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ Ажлын хэсгийн авч хэрэгжүүлэх ЭРЧИМЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл буюу Нийтийн мэдээллийн тухай, Хувь хүний нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл буюу Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай, Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлуулах.
- Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.
- Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.
- Олборлох үйлдвэрийн ил тод байдлын тухай, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Эрдэс баялгийн биржийн тухай хуулийн төслүүдийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

- Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их хуралд өргөн мэдүүлэх.
- Төрийн зарим чиг үүргийг дахин хуваарилах чиглэлээр хийгдсэн судалгааны нэгдсэн дүнг үндэслэн чиг үүргийн давхардлыг арилгах, төрийн зарим чиг үүргийг тухайн салбарын төрийн бус байгууллагад шилжүүлэх асуудлыг үе шаттай шийдвэрлэх.
- Худалдан авах ажиллагааны tender.gov.mn сайтыг боловсронгуй буюу 2-way болгох, автомат шалгаруулалтын функц нэмэгдүүлэх, шаардлагатай мэдээллийг нийтийн мэдээллийн системээс татдаг байх, санал өгөх процессыг хялбарчлах, төрийн байгууллагуудын ашиглалтыг нэмэгдүүлж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах.
- Төрийн үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг тогтмол хангах, тухай бүр шинэчлэх, иргэд, олон нийттэй харилцах төвийн “1111” тусгай утсаар төрийн байгууллагын хүнд суртал, авилгын шинж чанартай гомдол, мэдээллийг хүлээн авах, хариу өгөх үйл ажиллагааг сайжруулах.

НЗТ-ийн дүрмийн дагуу Монгол Улс нь НЗТ-ийн Шалгуур, стандартын дэд хорооноос эрхлэн явуулдаг хяналт шалгалтад хамрагдах түвшинд хүрээд байна. НЗТ-ийн зүгээс Монгол Улсыг “идэвхгүй байдал”-д шилжүүлэх эрсдлээс урьдчилан сэргийлэхийн тулд Монгол Улсын Засгийн газраас тухайн байдалд дүгнэлт хийснээр 2021-2023 оны дөрөв дэх ҮАҮТ-өөг боловсруулах явцад НЗТ-ийн хамтын бүтээлийн болзлуудыг хангаж ажиллахаар төлөвлөлөө.

НЗТ-ийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор бүтцийн өөрчлөлтийг хийхээр төлөвлөсөн бөгөөд НЗТ-ийн Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх, ажлын албыг шилжүүлэх ажлуудыг шат дараалалтайгаар хийхээр төлөвлөсөн байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ

Засгийн газар нь 2021-2023 оны ҮАҮТ-г боловсруулах явцад НЗТ-ийн “Оролцоо болон Хамтын бүтээлийн стандарт”-д тусгасан “оролцуулах” болзолыг бүрэн ханган ажилласан болно.


2021-2023 оны ҮАҮТ-г хамтран боловсруулах үйл явц:

- ИНБ-ууд 2021 оны 6 дугаар сарын 29-н болон 7 дугаар сарын 8-ны өдрүүдэд иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, хувийн хэвшил, улс төрийн нам болон олон улсын байгууллагын төлөөллийг оролцуулан НЗТ-ийн үйл ажиллагааны-IV төлөвлөгөөнд орох асуудлыг тодорхойлох хэлэлцүүлгийг эхлүүлсэн. Тухайн хоёр удаагийн цахим хэлэлцүүлэгт дээр дурьдагдсан салбарын нийт 104 хүн хамрагдаж, нийт 80 асуудлыг дэвшүүлж, нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай 23 асуудлыг онцлон эрэмблэв. (Хавсралт: Иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, хувийн хэвшил, улс төрийн нам, олон улсын байгууллагын төлөөлөл оролцсон хоёр удаагийн цахим хэлэлцүүлгийн тэмдэглэл, хөтөлбөр, оролцогчдын бүртгэл.)



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС


- ҮАҮТ-IV-өөг боловсруулах оролцогч талуудын төлөөлөл бүхий хамтарсан Ажлын хэсгийг 2021 оны 9 сарын 21-нд байгуулж, НЗТ-ийн оролцооны шалгуур үзүүлэлтийг хангах дарааллын дагуу гүйцэтгэх төлөвлөгөө гарган ажиллав. (Хавсралт: Ажлын хэсэг байгуулах Захирамж, Ажлын хэсгийн уулзалтын тэмдэглэл, хөтөлбөр, оролцогчдын бүртгэл.)



- ҮАҮТ-нд орох асуудлуудыг тодорхойлох цуврал хэлэлцүүлгийг төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэд, иргэний нийгмийн байгууллага тус бүр 2021 оны 9 дүгээр сарын 27-ноос 10 дугаар сарын 16-н хүртэлх хугацаанд танхим болон цахимаар зохион байгуулав. 35 төрийн байгууллагын төлөөлөл, хувийн хэвшил, иргэд, төрийн бус байгууллагын нийт 170 хүний оролцоотойгоор эхний саналыг авч нэгтгэв.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

УАУТ-IV-НИЙ ТӨСӨЛД
САНАЛ АВСАН БАЙДАЛ



Байгууллага	Тоо	Давтамж	Нийт
ЯАМД	8	3	24
АГЕНТЛАГ	6	3	18
ОРОН НУТАГ	21	1	1
Нийт	35	7	43

41 of 2020.10.31



- Иргэдийн оролцоог хангах, төсвийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, төрийн байгууллага, албан тушаалтны хариуцлагыг нэхэн шаардах чиглэлээр 47 асуудал яригдсан бөгөөд 12 ажлыг үнэлэн эрэмбэлж гаргав. Үүн дээр энэ оны 6-7 сард ИНБ, хэвлэл мэдээлэл, улс төрийн нам, судлаачид болон олон улсын байгууллагуудын 104 төлөөллөөс гарсан 80 саналаас эрэмблэгдсэн 23 санал нэмэгдэж, нийтдээ иргэний нийгмийн 35 асуудлыг НЗТ-ийн Ажлын хэсгийн хуралдаанд танилцуулагдав. Эдгээр саналыг НЗТ-ийн шалгуураар үнэлэн эрэмбэлэх ажлыг Ажлын хэсэг хийж гүйцэтгэв.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

- Ажлын хэсгийн өргөтгөсөн хурлаар НЗТ-ийн гарын авлагад заасан онооны үзүүлэлтээр дээрх 35 асуудлыг хэмжиж, ил тод нээлттэй байдал, иргэдийн оролцоо, олон хүний эрх ашигт үйлчлэх зэрэг үзүүлэлтээр хүн бүрийн оноог үнэлж 9 үүрэг амлалтын агуулгыг гаргав.
- Үүрэг амлалтын 9 агуулгыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргах багийг шинээр бүрдүүлж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас үүрэг амлалт тус бүрийг хариуцах яам, агентлагийн мэргэжилтэн, албан хаагч болон иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан 2021 оны 11 сарын 2-нд хагас өдрийн сургалт зохион байгуулж, нийт 34 хүн хамрагдав.



- НЗТ-ийн үйл ажиллагааны дарааллын дагуу 9 үүрэг амлалтыг төлөвлөгөө болгон боловсруулах багууд нь 2021 оны 11 дүгээр сарын 9-нд хамтарсан уулзалт хийж, үүрэг амлалтуудын уялдаа холбоо, сайжруулах асуудлыг ярилцан, холбогдох байгууллага хариуцах эзэн зэрэг мэдээллийг нягтлан Үйл ажиллагааны төлөвлөгөө бичих Ажлын хэсэгт өгөх даалгавартай ажиллав.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС



- Түүнчлэн 9 үүрэг амлалтад олон нийтээс санал хүсэлт шаардлага хүлээн авах зорилгоор Засгийн газрын цахим хуудсанд 11 дүгээр сарын 30-наас 12 дугаар сарын 6-ны хооронд байршуулж, 1111 төвөөр дамжуулан санал авахаар төлөвлөсөн бөгөөд энэ хугацаанд нэмэлт санал хүсэлт ирээгүй болно.
- Нээлттэй засгийн түншлэлийн 2021-2023 оны үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөний төсөлд тусгах тэргүүлэх чиглэл, тулгамдаж буй асуудал, түүнийг шийдэх арга зам, үүрэг амлалт нь төрийн байгууллага, иргэд, иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, хувийн хэвшлийн 200 гаруй төлөөллийг оролцуулан 2021 оны 6-11 дүгээр сарын хугацаанд цахим болон танхимаар, төрийн байгууллагаас албан бичгээр нийт 5 удаагийн хэлэлцүүлэг, уулзалтаас гарсан зорилт, арга хэмжээний саналд үндэслэгдсэн болно.

**НЭЭЛТТЭЙ ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН АМЛАЛТ,
ЗОРИЛТОТ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД**

Зорилт-1 Эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг сайжруулах	
Хэрэгжих хугацаа: 2021– 2023	
Манлайлж хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
Үүрэг амлалтын тодорхойлолт	
Энэхүү үүрэг амлалтаар олон нийтэд тулгамдаж буй ямар асуудлыг шийдвэрлэх вэ?	Эрдэс баялгийн салбар нь улсын төсвийн орлогын 20-30 хувийн бүрдүүлж ирсэн Монгол Улсын эдийн засгийн тулгуур салбар юм. ¹ Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тодорхойлсноор уул уурхайн салбар нь цаашдаа ч ойрын 30 жилийн хугацаанд эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг хэвээр байхаар байна. ² Гэсэн хэдий ч энэ салбарт ил тод байдал, олон нийтийн хяналт оролцоог нэмэгдүүлж, төр, хувийн хэвшлийн хариуцлагыг нэмэгдүүлэх сайн засаглалыг төлөвшүүлэх хэрэгцээ шаардлага тулгамдсан асуудал болоод байна. 2021 онд Байгалийн баялгийн засаглалын индексээр Монгол Улс авч болох 100 онооноос 70 оноо авсан ба ил тод байдлыг хангах чиглэлээр дараах арга хэмжээ авахыг зөвлөмж болгожээ. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар нь нээлттэй өгөгдлийн зарчмуудыг баримталж, цахим өгөгдөл ашиглах боломжийг сайжруулах, лиценз, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын талаарх мэдээллийг илүү нарийвчлалтай, компьютерт уншуулах боломжтой байдлаар цахим хэлбэрээр нийтлэх нь чухал гэж зөвлөжээ. ³ Ашигт малтмал, газрын тосны газраас мэдээлдэг тусгай зөвшөөрлийн мэдээллийг цахим

¹ <https://www.eitimongolia.mn/p/21>

² Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, <https://legalinfo.mn/mn/detail/15406>

³ Natural Resource Governance Index 2021, <https://resourcegovernanceindex.org/country-profiles/MNG/mining?years=2021>

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

	<p>хуудсаараа мэдээлдэг ч ОУИТБС-ын шаардлагыг хангахуйц бүрэн бус, машинаар унших боломжтой бус байна. Түүнчлэн үйлдвэрлэл, борлуулалтын мэдээлэл нь төслийн түвшний задаргаатай бус, Гаалын ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний статистикийн газраас гаргадаг мэдээллүүд хоорондоо зөрүүтэй байна.</p> <p>Монгол Улс 2006 оноос Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)-ыг хэрэгжүүлж байгаа боловч эрх зүйн оновчтой зохицуулалтыг өнөө хүртэл бий болгож чадаагүйгээс төрийн байгууллагуудын оролцоо суларч, ил тод байдлыг төрийн үйл ажиллагаанд хэвшүүлэн хэрэгжүүлэх (mainstreaming), гэрээний ил тод байдлыг хангах, эцсийн өмчлөгчийн мэдээллийг нийтэд нээлттэй болгох зэрэг шинэ шаардлагуудыг хэрэгжүүлэх сорилттой тулгарч байна.</p> <p>Иймд ашигт малтмалын хайгуулын шатнаас эхлэн орлого, үр өгөөжийг зарцуулах, хуваарилах хүртэлх байгалийн баялаг ашиглахтай холбоотой бүхий л үе шатыг хамарсан ил тод байдал, олон нийтийн хяналтыг бий болгох.</p> <p>Эрдэс баялгийн салбарт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, эрх тэгш шударга өрсөлдөөн бүхий бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн салбарын хөгжлийг тэлэх.</p> <p>Иргэдийг мэдээллээр хангах, хэлэлцүүлэгт идэвхтэй оролцуулах, байгалийн баялгийн үр өгөөжийг удирдах бодлого, шийдвэр зөв оновчтой болгох шаардлагатай байна.</p>
--	--

<p>Энэ үүрэг амлалтыг тодорхойлно уу.</p>	<p>Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийг батлан гаргах замаар уг салбарт ил тод байдлын дэлхийн стандартыг нэвтрүүлж, гэрээ, эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах, уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын засаглалыг сайжруулах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоог баталгаажуулах эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.</p>
---	--

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

Олон нийтэд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд энэ үүрэг амлалт нь хэрхэн хувь нэмэр оруулах вэ?

- Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг УИХ-ын 2021 оны Намрын чуулганаар хэлэлцүүлэхээр өргөн барих,
- Эрдэс баялгийн мэдээллийн нэгдсэн сан байгуулах: Мэдээллийн санд ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл, газар, ус ашиглах зөвшөөрөл, дүгнэлт, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө тайлан, эрдэс баялгийн нөөц, олборлолт, борлуулалтын тоо хэмжээ, үнэ, орлого, улс орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамж, олборлолтод өртсөн нөхөн сэргээлт хийсэн газрын хэмжээ, байгаль орчныг хамгаалахад зарцуулсан хөрөнгийн хэмжээ, төрийн захиргааны байгууллагаас газрын хэвлийн баялаг ашиглахтай холбоотой асуудлаар байгуулсан бүх төрлийн гэрээ, ялангуяа төрийн өмчит компаниудын худалдан авалт, борлуулалтын гэрээ, эцсийн өмчлөгчийн мэдээлэл, төрийн байгууллагатай хийсэн санхүүгийн бүх төрлийн гүйлгээ, шилжүүлэг, төсвийн хуваарилалт, Үндэсний баялгийн сангийн орлого, зарцуулалт, үр ашгийн мэдээлэл, санхүүгийн тайлан зэрэг мэдээллийг нээлттэй өгөгдөл хэлбэрээр байршуулсан байна.
- Төслийн түвшинд тайлагнах, ил тод болгох: Олборлосон, боловсруулсан, борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, ашигт малтмал ашигласны төлбөр, газрын төлбөр, усны төлбөр, олборлолтод өртсөн газар нутгийн хэмжээ, байгаль орчныг хамгаалахад зарцуулсан хөрөнгийн хэмжээ зэрэг боломжтой бүх мэдээллийг төсөл тус бүрээр задаргаатайгаар тайлагнадаг болно.
- Ил тод байдлыг хангах чиглэлээр төрийн холбогдох байгууллага, төрийн өмчит компаниудын чиг үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, өөрийн үйл ажиллагаанд хамаарах мэдээллийг тухай бүр нээлттэй өгөгдөл хэлбэрээр мэдээллийн санд байршуулж хэвшүүлэх,

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

	<ul style="list-style-type: none"> - Мэдээллийн сангийн хэвийн, аюулгүй үйл ажиллагааг хангах техник, технологийн шийдлийг олж хэрэгжүүлэх, - Ил тод байдлыг хангах, эрдэс баялгийн салбарт бодлого, шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангах механизмыг бүрдүүлэх. ОУИТБС-ын Үндэсний зөвлөл дэх иргэний нийгмийн төлөөлөл, эрх үүргийг хуульчилснаар эрдэс баялгийн салбарын бодлого, шийдвэр, түүний хэрэгжилтэд албан ёсоор оролцох боломж бүрдэнэ.
<p>Энэ үүрэг амлалт нь яагаад НЗТ-ийн үнэт [эрхэмлэх] зүйлсэд хамааралтай вэ?</p>	<p>Ил тод байдал, мэдээллийн чанар хүртээмжийг дээшлүүлнэ.</p> <p>Олон нийтийн зүгээс төр засгийн шийдвэр гаргалтад нөлөөлөх боломжийг нэмэгдүүлнэ. Иргэний нийгэмд таатай орчныг бүрдүүлнэ.</p> <p>Төрийн албан тушаалтнууд үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээлгэх дүрэм, журам, арга боловсронгуй болгоно.</p>
<p>Нэмэлт өгөгдөл мэдээлэл</p>	<ul style="list-style-type: none"> ● Үүрэг амлалтыг хэрэгжүүлэх төсөв Хуулийн төсөлтэй холбоотой судалгаа, үнэлгээ, тооцоо хийгдсэн тул Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг УИХ-аар батлуулахад ямар нэг зардал гарахгүй. ● Засгийн газрын бусад хөтөлбөрүүдтэй уялдаж буй эсэх Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.8 –д “Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангах”, 3.2-т “Ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх” зорилтуудыг тус тус тусгажээ.⁴ <p>Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөл нь УИХ-ын 2021 оны Намрын чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад мөн тусгагдсан болно.</p>

⁴Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр <https://legalinfo.mn/mn/detail/15586>

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

	<ul style="list-style-type: none"> ● Үндэсний хөгжлийн бодлого үндсэн чиглэл, бусад салбарын буюу орон нутгийн хөтөлбөр төлөвлөгөөтэй уялдсан эсэх Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 4.2.1-д Хариуцлагатай уул уурхайн хөгжүүлэх зорилт дэвшүүлжээ. ● [НҮБ-ын] Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан эсэх Эдийн засгийн гол салбарын нэг болох эрдэс баялгийн салбарт ил тод байдлыг хангах нь салбарын өсөлт хөгжлийг дэмжихээс гадна нийгэм, эдийн засгийн бусад салбарын хөгжилд эергээр нөлөөлж, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгуудыг хэрэгжүүлэхэд зохих хувь нэмэр оруулна. Тухайлбал, ядуурлыг бууруулах, эрүүл мэнд, чанартай боловсролыг дэмжих, жендерийн тэгш байдлыг хангах, эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байр бий болгох, инноваци болон дэд бүтцийг хөгжлийг нэмэгдүүлэх, тэгш бус байдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, хуурай газрын эко системийг хамгаалах, энх тайван шударга ёсыг цогцлоох, хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх зорилгын хэрэгжилтийг дэмжих юм. ● Жендерийн тандалт судалгаа шинжилгээ Эрдэс баялгийн ил тод байдлын тухай хуулийг батлан гаргаснаар уул уурхай, газрын тосны салбар дахь эрэгтэй, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, орон нутагт байгуулагдсан хамтын ажиллагааны гэрээний дагуу хэрэгжиж буй эмэгтэйчүүдийн оролцоо, хөдөлмөрийн эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр, санаачилгын мэдээллийг ил тод болгоно. Эдгээр мэдээлэлд дүн шинжилгээ хийх замаар уул уурхайн салбараас эмэгтэйчүүдэд үзүүлэх нөлөөлөл, тэдгээрийг шийдвэрлэх бодлогын шийдлүүдийг гаргахад хувьд нэмэр оруулна.
Хүрэх үр дүнгийн тодорхойлолт	Байгалийн баялгийн үр өгөөжийг тогтвортой хөгжлийн төлөө, өнөө ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

	хуваарилах, баялгийн жинхэнэ өмчлөгч болох иргэдийн мэдэх эрхийг хангах Үндсэн хуулийн үзэл санааг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.	
Биелэлтийн дараа авах арга хэмжээ/алхамууд	<ul style="list-style-type: none"> • Хуулийн хэрэгжилт, үр дагаврын үнэлгээ хийх • Хуулийг сурталчлах арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжилтийг эрчимжүүлэх • Эрдэс баялгийн мэдээллийн санд нээлттэй өгөгдлийн шаардлагын дагуу үнэлгээ хийх • Хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн байгууллагуудын нээлттэй өгөгдөл ашиглах чадавхыг бэхжүүлэх 	
Хүрэх үе шатуудын хэрэгжилтийн байдал	Эхлэх огноо:	Дуусгах огноо:
- Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн УИХ-ын 2021 оны Намрын чуулганаар хэлэлцүүлэхээр өргөн барьж, хэлэлцүүлэх	2021.6.30	2022.6.30
- Эрдэс баялгийн мэдээллийн нэгдсэн сан байгуулж, нээлттэй өгөгдлийг бүрдүүлэх	2022.6.30	2022.6.30
- Ил тод байдлыг хангах чиглэлээр төрийн холбогдох байгууллага, төрийн өмчит компаниудын чиг үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, өөрийн үйл ажиллагаанд хамаарах мэдээллийг тухай бүр нээлттэй өгөгдөл хэлбэрээр мэдээллийн санд байршуулж хэвшүүлэх. Одоо ОУИТБС-ын тайлангаар дамжуулан нийтэд ил тод болгодог мэдээллүүдийг төрийн байгууллагууд өөрсдийн цахим хуудсаар дамжуулан шууд мэдээлдэг болно.	2022.6.30	2022.6.30

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

<p>- Мэдээллийн сангийн хэвийн, аюулгүй үйл ажиллагааг хангах техник, технологийн шийдлийг олж хэрэгжүүлэх.</p>	<p>2022.6.30</p>	<p>2022.6.30</p>
<p>- Ил тод байдлыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилтийг улсын төсөвт суулган шийдвэрлэх,</p>	<p>2022.10.1</p>	<p>2022.11.15</p>
<p>- Ил тод байдлыг хангах, эрдэс баялгийн салбарт бодлого, шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангах механизмыг бүрдүүлэх.</p>	<p>2022.6.30</p>	<p>2023.6.30</p>
<p>Холбоо барих өгөгдөл мэдээлэл</p>		
<p>Манлайлж хариуцан хэрэгжүүлэх байгууллага</p>	<p>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам</p>	
<p>Хэрэгжүүлэгч байгууллагын хариуцсан ажилтан</p>	<p>Уул уурхай хүнд, үйлдвэрийн яам (УУХҮЯ) Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ) baasanpurev@mmhi.gov.mn 976-51-264057 /Т. Баасанпүрэв</p>	
<p>Албан тушаал, Газар, хэлтсийн нэр</p>	<p>Д.Дамба, Г.Мишээлт /УУХҮЯ-ны Судалгаа, хөрөнгө оруулалтын газар/ damba@mmhi.gov.mn Утас -99187723 Төрийн захиргаа, удирдлагын газрын мэргэжилтэн О.Туяацэцэг</p>	
<p>Цахим шуудангийн хаяг, суурин болон гар утасны дугаар</p>	<p>tuyatsetseg@mmhi.gov.mn +(976)_89119968</p>	
<p>Бусад оролцогч талууд</p>	<p>Засгийн газрын яам, агентлаг:</p>	<p>Төрийн байгууллага: Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Монгол банк, Сангийн яам, Авлигатай тэмцэх газар, Байгаль орчин, ачлал жуулчлалын яам,</p>

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

Иргэний нийгмийн байгууллага, Хувийн хэвшил, Олон талт байгууллага, Үндэсний хороо, Ажлын хэсэг	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Үндэсний статистикийн хороо, Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн алба, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар, аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга, ИТХ Иргэний нийгэм: Төлсөн Авснаа Нийтэл (ТАН) иргэний нийгмийн эвсэл
Нэмэлт өгөгдөл, мэдээлэл:	

Зорилт-2: Мэдээллийн ил тод байдлын эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар төрөөс мэдээлэл авах иргэдийн эрхийг баталгаатай хангаж, төрийн ил байдлыг сайжруулах	
Хэрэгжих хугацаа: 2021– 2023	
Манлайлж хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хууль зүй, дотоод хэргийн яам
Үүрэг амлалтын тодорхойлолт	
Энэхүү үүрэг амлалтаар олон нийтэд тулгамдаж буй ямар асуудлыг шийдвэрлэх вэ?	Төрийн болон албаны нууцын тухай хууль нь практикт “төрийн нууц”, “албаны нууц” нэрийн дор мэдээллийг хяналтгүй нууцлах, иргэнд мэдээлэл өгөхөөс цааргалах, төрийн байгууллага, албан тушаалтны алдаа, дутагдлыг нуух, хаацайлах арга хэрэгсэл болоод байна. Олон нийтийн мэдэх эрхийг хангаж, төрийн мэдээлэл дээд зэргээр ил тод байх, мэдээллийг зөвхөн нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор нууцлах зарчимд нийцүүлэн, аливаа байгууллага өөрийн хүсэлтээр мэдээллээ нууцалж, нийтийн мэдэх эрхийг хөндөхийг хориглож, эрх зүйн орчны сайжруулалт хийх шаардлагатай байна. 2/ Цар тахлын нөхцөлд "инфодемик" буюу “мэдээллийн

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

	<p>цар тахал” газар авч иргэд хуурамч, ташаа мэдээллийн улмаас давхар хохирох нөхцөл үүсгэж байна. Ялангуяа мэдээллээс хол алслагдсан бүс нутагт амьдардаг, орлого багатай, мэдээллийн боловсрол багатай, эсвэл тусгаарлагдсан хүмүүст дээрх нөхцөл байдал хүндээр тусдаг нь өнгөрсөн жилүүдийн туршлагаас тодорхой харагдлаа. Цар тахал буюу хямралын үед цахим орчинд өөрийн үзэл бодлоо илэрхийлж төрийн үйлчилгээг шүүмжилсэн иргэдийг торгох, саатуулах, сануулах арга хэмжээ авсан тохиолдол болон хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудын мэдээлэл авах, түгээх, хэвлэн нийтлэх эрхийг зөрчих, цензурдэх, хязгаарлах тохиолдлууд их гарав. Орон нутгийн удирдлагын зүгээс хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, дарамт шахалт үзүүлэх, сүрдүүлэх, хөндлөнгөөс нөлөөлөх зэргээр мэдээлэл авах эрхийг нь зөрчих тохиолдол нэлээд илрэв. Цаашид хямралын үеийн харилцаа холбоог зөв зохион байгуулах, нийтийн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь чухал болж байна.</p>
<p>Энэ үүрэг амлалтыг тодорхойлно уу.</p>	<p>“Нууц” ангилал дор оруулж аливаа мэдээллийг олон нийтэд хүргэхгүй байх явдлыг таслан зогсоох, түүнчлэн цар тахал зэрэг онцгой байдлын үед иргэдийн мэдээлэл цаг хугацаанд нь боломжит хувилбараар хүлээн авах, мэдэх эрхийг хангах эрх зүйн орчныг яаралтай сайжруулах шаардлагатай байна.</p> <p>Мэдээлэл олж авах эрхийг хангаснаар төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрх зүйн таатай орчныг бий болгох. Үүний тулд дээр дурдсан хууль эрх зүйн зохицуулалтыг олон улсын эрх зүйн хэм хэмжээнд, тухайлбал Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйл, түүний үзэл санаанд нийцүүлэн өөрчлөх.</p> <p>1/ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль ба Төрийн болон албаны нууцын тухай хуульд НҮБ-ын хүний эрхийн байгууллагаас тогтоосон “мэдээлэлтэй байх эрхийг хязгаарлахад баримтлах</p>

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

	<p>шалгуур”-ыг хуульчлах. 1/ тухайн мэдээлэл нь хуульд заасан хууль ёсны ашиг сонирхолтой холбоотой байх, 2/ тухайн мэдээллийг ил болгох, задруулах нь хуулиар хамгаалсан ашиг сонирхолд ноцтой хохирол учрахыг хохирлын үнэлгээгээр заавал тогтоосон байх, 3/ тэрхүү учрах ноцтой хохирол нь олон нийтийн мэдээлэлтэй байх ашиг сонирхлоос илүү чухал байх гурван нөхцөл нэгэн зэрэг хангасан тохиолдолд мэдээллийг нийтэд мэдээлэхгүй байх, төрийн болон албаны нууцад хамааруулах талаар тусгах.</p> <p>Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13.2-т “Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь энэ зүйлийн 13.1-д заасан жагсаалтын хүрээнд салбар, байгууллагын хэмжээнд нууцлах төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг боловсруулж, тагнуулын байгууллагын саналыг авч Засгийн газраар батлуулна”, 14.1-т “Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тухайн хариуцсан байгууллага боловсруулж, асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр батална” гэснийг хүчингүй болгож, төрийн нууцын жагсаалт батлах тухай тусгайлсан хууль гаргах.</p> <p>2/ Төрийн шийдвэр гаргах үйл явцын ил тод байдлыг хангах, иргэдийн оролцоог хангахтай холбоотой Хууль тогтоомжийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай хууль, Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх замаар хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээг тодорхойлж хэрэгжүүлэх.</p>
<p>Олон нийтэд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд энэ үүрэг амлалт нь хэрхэн хувь нэмэр оруулах вэ?</p>	<p>1/ Нээлттэй мэдээллийн асуудлаарх олон улсын хөндлөнгийн тайлангууд дахь Монгол Улсын үзүүлэлт сайжрах нөхцөл болно.</p> <p>Дээрх амлалтыг хэрэгжүүлэх нь дараах үе шаттай байна:</p> <ul style="list-style-type: none"> • Холбогдох хуулийн төслийг хууль санаачлагч боловсруулж, Засгийн газарт танилцуулж санал авах; • Засгийн газраас хуулийн төслийг УИХ-д өргөн барих;

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

	<ul style="list-style-type: none"> • УИХ-аас холбогдох хуулийн төслийг хэлэлцэж, батлах • Батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар УИХ-аас тухай бүр дүгнэх, хэлэлцэх; • Батлагдсан хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар хууль хэрэгжүүлэгчдэд зориулсан сургалт, хэлэлцүүлгийг тухай бүр хийх; • Дээр дурдсан үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог тухай бүр хангах; <p>2/ Мэдээллийн чанартай хүртээмжийг дээшлүүлэхэд мэдээлэл харилцааны оролцогч талууд харилцан ярилцах, ойлголцох, хамтран ажиллах систем бүрдэж, иргэд-хэвлэл мэдээлэл- төрийн итгэлцэл дээшилнэ. Нийтийн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлснээр ялангуяа эмзэг бүлгийн иргэдийн мэдээлэл авах эрх хангагдана.</p>
<p>Энэ үүрэг амлалт нь яагаад НЗТ-ийн үнэт [эрхэмлэх] зүйлсэд хамааралтай вэ?</p>	<p>•Ил тод [нэвт тунгалаг] байдал Үүрэг амлалт нь илүү их өгөгдөл мэдээллийг ил нээлттэй болгох, мөн ил нээлттэй байгаа өгөгдөл мэдээллийн чанарыг сайжруулах, олон нийтэд өгөгдөл мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх төдийгүй мэдээлэл авах эрхийг хангана.</p> <p>•Иргэний оролцоо Үүрэг амлалт нь төр засгийн шийдвэр гаргалтын талаар олон нийт мэдээлэл авах, түүнд нөлөөлөх боломж чадамжийг сайжруулна.</p> <p>•Төр засгийн хариуцлагыг сайжруулах Үүрэг амлалт нь төрийн албан тушаалтнууд үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээлгэхэд шаардлагатай мэдээллийг ил тод болгоно.</p>
<p>Нэмэлт өгөгдөл мэдээлэл</p>	<ul style="list-style-type: none"> • НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдаж буй байдал: “Тогтвортой хөгжлийн төлөө аюулгүй, бүх талын оролцоог хангасан нийгмийг хөгжүүлж, хүн бүрийг хуулиар хамгаалуулах боломжоор хангах, бүх түвшинд үр дүнтэй, хариуцлагатай, бүх талын

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

	<p>оролцоог хангасан институтийг бий болгох” 16 дугаар зорилтын Зорилт 16.5 /Авлига, хээл хахуулийн бүх хэлбэрийг үлэмж хэмжээгээр багасгах/, Зорилт 16.6 /Бүх түвшинд үр дүнтэй, хариуцлагатай, ил тод үйл ажиллагаатай институтийг хэвшүүлэх/, Зорилт 16.7 /Бүх түвшинд хурдан шуурхай, бүх талын оролцоог хангасан, оролцооны аргад тулгуурласан, төлөөллийн шийдвэр гаргадаг болох/, Зорилт 16.10 /Үндэсний хууль тогтоомж болон олон улсын гэрээ хэлэлцээрт нийцүүлэн олон нийтийг мэдээлэл олж авах боломжоор хангах, үндсэн эрх чөлөөг хамгаалах/</p> <ul style="list-style-type: none">• 2020 онд Монгол Улс 3 дахь удаагийн илтгэлээ хэлэлцүүлээд, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулах талаар НҮБ-ын гишүүн улсуудаас дараах зөвлөмжийг өгсөн. Үүнд: Зөрчлийн тухай хуулийн 6.21 дэх заалтыг хүчингүй болгох замаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах - 70 (ИБУИНХУ); <p>-Дээрх зүйл заалт хүчингүй болсон боловч Эрүүгийн хуулийн 13.14 дахь заалтаар үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл олж авах эрх чөлөөг улам хумьсан.</p> <p>УИХ-аас баталсан бодлогын баримт бичгүүдэд мэдээлэл олж авах эрхийг хангах талаар зарим асуудлууд тусгагдсан байна. Тодруулбал, УИХ-ын 2010 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.6.4.1-д “Хуулиар хориглоогүй мэдээллийг чөлөөтэй хайх, олж авах, үүсгэх, дамжуулах, түгээх эрх, эрх чөлөөг хангах, мэдээллийн дэд бүтэц, түүний бүрдэл хэсэг, үйлчилгээнд чөлөөтэй хандах боломжийг бүрдүүлснээр мэдээллийн хүртээмжтэй байдал хангагдана”. 3.6.4.5-д “Хэвлэл мэдээллийн байгууллагад хуулиар хориглоогүй мэдээллийг эрэн сурвалжилж олж авах, нийгэмд түгээхэд таатай эрх зүйн орчныг бүрдүүлнэ” гэж заасан. УИХ-ын 2016 оны 51 дүгээр тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 2.1.8-д “иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах ...”-аар тус тус зохицуулжээ.</p>
--	---

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

<p>Хүрэх үр дүнгийн тодорхойлолт</p>	<p>Төрийн байгууллага, албан тушаалтны зүгээс мэдээллийг нууц нэрийн дор өгөхгүй байх, дутуу өгөх, өгөхөөс зайлсхийх явдал үгүй болно. Нууцын хууль тогтоомж нь Үндсэн хууль, олон улсын гэрээнд бүрэн нийцнэ.</p> <p>Зорилтот бүлгийн иргэдэд зориулсан хямралын үеийн харилцаа холбоог сайжруулах хүрээнд дараах оролцогчдыг найдвартай, хариуцлагатай мэдээллийг түгээх үүргээ гүйцэтгэхэд бэлтгэнэ. Мөн оролцогч талуудын хоорондын мэдээлэл харилцааны талаарх мэдлэгийг дээшлүүлэхийн зэрэгцээ тэдний харилцаа холбоог сайжруулна.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн эрх бүхий байгууллагуудын төлөөлөл, мэргэжилтнүүд /УОК, ОБЕГ, ЭМЯ, ХӨСҮТ, НЭМҮТ гэх мэт - Мэргэжлийн туршлагатай сэтгүүлчид, эсвэл хэвлэл мэдээллийн байгууллагатай холбоотой ажилладаг хүмүүс - Зорилтот бүлгийн иргэдтэй сайн харилцаатай, сүлжээ сайтай иргэний нийгэм, ТББ-ын төлөөлөгчид - Зорилтот бүлгийг хариуцсан орон нутгийн удирдлагууд, тухайн бүс нутгийн шийдвэр гаргагчид, давуу талтай байх салбарууд: эрүүл мэнд, гамшгийн менежмент гэх мэт. - Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн төлөөлөгчид, интернэт дэх сувгууд, үзэгчдэд хандах формат, сүлжээтэй, нөлөө бүхий, нэр хүндтэй хүн, сэтгүүлч 	
<p>Биелэлтийн дараа авах арга хэмжээ/алхамууд</p>	<ul style="list-style-type: none"> ● Шинэчлэгдсэн хууль тогтоомжийг таниулах, сурталчлах ● Шинэчлэгдсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг тогтмол хянаж шалгах , үр дүнг олон нийтэд мэдээлэх ● Иргэд, сэтгүүлчид олон нийтийн эрх ашигт хамааралтай мэдээллийг саадгүй олж авах дадал хэвшилтэй болно. 	
<p>Хүрэх үе шатуудын хэрэгжилтийн байдал</p>	<p>Эхлэх огноо:</p>	<p>Дуусгах огноо:</p>

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

Төрийн болон албаны нууцын жагсаалтыг мэдээллийн ил тод байдлын зорилгод нийцүүлэн өөрчлөх	2021.11	2023.09
Цар тахал, хямралын үеийн мэдээллийн ил тод байдлыг сайжруулах	2021.11	2023.09
Монгол Улсын Үндсэн Хуульд оруулсан “Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй” гэх эрхийг холбогдох хуульд нэмж оруулах	2021.11	2023.09
Шийдвэр гаргах үйл явцын ил тод байдлыг хангах, иргэдийн оролцоог хангахтай холбоотой Хууль тогтоомжийн тухай хууль, Нийтийн сонсголын тухай хууль, Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх, барим нотолгоонд үндэслэсэн сайжруулах арга хэмжээний төсөл боловсруулж хэрэгжүүлэх - Хэрэгжилтийн үнэлгээ - Хэрэгжүүлэх	2021.11	2023.06
Авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоо, шууд хяналтыг хэрэгжүүлэх идэвхи, санаачлагыг дэмжиж, олон нийтийн зөвлөлийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлж, эрх зүйн орчныг сайжруулах	2021.11	2023.06
Холбоо барих өгөгдөл мэдээлэл		
Манлайлж хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хууль зүй, дотоод хэргийн яам	
Хэрэгжүүлэгч байгууллагын хариуцсан ажилтан	П.Сайнзориг	

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

Албан тушаал, Газар, хэлтсийн нэр		Хууль зүйн бодлогын газрын дарга
Цахим шуудангийн хаяг, суурин болон гар утасны дугаар		sainzorig@mojha.gov.mn утас: 261957
Бусад оролцогч талууд	Засгийн газрын яам, агентлаг: Иргэний нийгмийн байгууллага, Хувийн хэвшил, Олон талт байгууллага, Үндэсний хороо, Ажлын хэсэг	Засгийн газрын ХМОНХГ Эрүүл мэндийн яам Авилгатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөл Улсын онцгой комисс, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Хүний эрхийн үндэсний комисс, Хэвлэл мэдээллийн зөвлөл Хэвлэлийн хүрээлэн Монголын үндэсний олон нийтийн радио телевиз, Монголын телевизүүдийн холбоо, Монголын сайтын холбоо Монголын өргөн нэвтрүүлгийн холбоо Монголын сонины холбоо
Нэмэлт өгөгдөл, мэдээлэл:		

Зорилт-3: Төрийн худалдан авах ажиллагаанд сүүлийн үеийн дэвшилтэт технологид тулгуурлан хүний оролцоог багасгах, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангах	
Хэрэгжих хугацаа: 2021-2023	
Манлайлж хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Төрийн худалдан авах ажиллагааны газар, Сангийн яам
Үүрэг амлалтын тодорхойлолт	

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

<p>Энэхүү үүрэг амлалтаар олон нийтэд тулгамдаж буй ямар асуудлыг шийдвэрлэх вэ?</p>	<ul style="list-style-type: none"> • Тендерийн үнэлгээний үйл ажиллагаа ил тод бус • Тендер шалгаруулалтын үр дүнг шударга бус гэж иргэд, олон нийт үздэг • Төр, иргэн, олон нийтэд мэдээллийн хүртээмж тэнцвэргүй
<p>Энэ үүрэг амлалтыг тодорхойлно уу.</p>	<ul style="list-style-type: none"> • Хууль эрх зүйн орчинг сайжруулсан байна. • Худалдан авах ажиллагааны цахим систем” www.tender.gov.mn/-ийг худалдан авах ажиллагаанд оролцогч талуудын системүүдтэй холбож, мэдээлэл солилцдог болсон байна. • Худалдан авах ажиллагааны хариуцлагын тогтолцоог төгөлдөржүүлж, RED FLAG INDICATOR бий болгоно. • Худалдан авах ажиллагааны гэрээний гүйцэтгэл, явцын мэдээллийг бүрдүүлж, Нээлттэй гэрээний олон улсын стандартын дагуу нээлттэй түгээнэ. <p>“Худалдан авах ажиллагааны цахим систем” www.tender.gov.mn/-д нэмэлт хөгжүүлэлт хийж, тендерийн баримт бичиг боловсруулах, тендерийг үнэлэх үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, хүний оролцоог багасгасан байна.</p>
<p>Олон нийтэд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд энэ үүрэг амлалт нь хэрхэн хувь нэмэр оруулах вэ?</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авч буй худалдан авах ажиллагааны үнэлгээ, хууль журамд заасны дагуу өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, хариуцлагатай зохион байгуулагдсанаар төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөж дээшилсэн байна. Худалдан авах ажиллагааны дагуу зохион байгуулагдсан гэрээний гүйцэтгэлийн мэдээллийг ил тод нээлттэй өгөгдөл хэлбэрээр түгээснээр иргэд, олон нийтийн зүгээс дүн шинжилгээ хийх, эрсдлийн менежментийг нэвтрүүлэх, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах боломж бүрдэнэ.</p>
<p>Энэ үүрэг амлалт нь яагаад НЗТ-ийн үнэт [эрхэмлэх] зүйлсэд хамааралтай вэ?</p>	<ul style="list-style-type: none"> • Ил тод байдал нэмэгдэнэ • Иргэдийн оролцоо нэмэгдэнэ • Авлига, ашиг сонирхлын зөрчил буурна
<p>Нэмэлт өгөгдөл мэдээлэл</p>	<p>Төсөв: Улсын төсөв, олон улсын байгууллагуудын хөрөнгө оруулалт</p>

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

	Уялдаа: “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” “Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.1.16 дахь заалт	
Хүрэх үр дүнгийн тодорхойлолт	Төрийн худалдан авах ажиллагаанд сүүлийн үеийн дэвшилтэт технологид тулгуурлан хүний оролцоог багасгасан байна. - Иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоот хяналтын үр дүнг жил тутам оролцогч талуудад хэлэлцүүлж, олон нийтэд тайлагнасан байна.	
Биелэлтийн дараа авах арга хэмжээ/алхамууд	Үүрэг амлалтын биелэлтэд хяналт тавих, судалгаа хийх, олон нийтэд тогтмол мэдээлэх	
Хүрэх үе шатуудын хэрэгжилтийн байдал	Эхлэх огноо:	Дуусгах огноо:
Хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох	2021.11.01	2022.09.30
Цахим каталогийн системийн өгөгдлийг цуглуулж, ашиглалтанд оруулах	2021.11.01	2022.06.30
Худалдан авах ажиллагаанд оролцогч талуудын системүүдтэй ХУР систем болон бусад арга хэлбэрээр холбох, мэдээлэл солилцоог нэмэгдүүлэх, төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах	2021.11.01	2023.06.30
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах бүр захиалагч байгууллагын худалдан авах ажиллагааны гэрээний гүйцэтгэл, явцын мэдээллийг бүрдүүлж, OCDS форматаар нээлттэй түгээнэ.	2021.11.01	2022.06.30

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

Худалдан авах ажиллагааны хариуцлагын тогтолцоог төгөлдөржүүлж, RED FLAG INDICATOR бий болгоно, олон нийт ил тод түгээнэ.		2022.02.01	2022.12.01
Захиалагч, тендерт оролцогч цахим системийн үйл ажиллагааг сурталчлан таниулж, хяналт сайжирсан эсэхэд судалгаа хийж, хэлэлцүүлэг өрнүүлсэн байна.		2021.11.01	2023.06.30
Холбоо барих өгөгдөл мэдээлэл			
Манлайлж хариуцан хэрэгжүүлэх байгууллага		Сангийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар	
Хэрэгжүүлэгч байгууллагын хариуцсан ажилтан		Сангийн яам , Хууль, эрх зүйн газар, Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэс Ц.Батзул Төрийн худалдан авах ажиллагааны газар , Цахим худалдан авах ажиллагаа, мэдээллийн технологийн хэлтэс Н.Цэрэнсамбуу	
Албан тушаал, Газар, хэлтсийн нэр		Хууль, эрх зүйн газар, Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэс Төрийн худалдан авах ажиллагааны газар, Цахим худалдан авах ажиллагаа, мэдээллийн технологийн хэлтэс	
Цахим шуудангийн хаяг, суурин болон гар утасны дугаар		batzul_ts@mof.gov.mn ; tserensambuu@tender.gov.mn ; 267648, 7272-0000	
Бусад оролцогч талууд	Засгийн газрын яам, агентлаг: Иргэний нийгмийн байгууллага, Хувийн хэвшил, Олон	Төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нар, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд, Төсөл хэрэгжүүлэгч нэгжүүд, Иргэний нийгмийн байгууллагууд, Худалдан авах ажиллагааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд	

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

	талт байгууллага, Үндэсний хороо, Ажлын хэсэг	
Нэмэлт өгөгдөл, мэдээлэл:		

Зорилт-4: Иргэний нийгмийн орон зай, төлөвшил, эвлэлдэн нэгдэх эрхийг дэмжиж, хараат бусаар бие даан, өөрийгөө удирдан явуулах боломжийг бүрдүүлсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгох

Хэрэгжих хугацаа: 2021-2023

Манлайлж хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар Хууль зүй, дотоод хэргийн яам Улсын бүртгэлийн ерөнхий газар
---	--

Үүрэг амлалтын тодорхойлолт

Энэхүү үүрэг амлалтаар олон нийтэд тулгамдаж буй ямар асуудлыг шийдвэрлэх вэ?	Монгол Улсын хэмжээнд эвлэлдэн нэгдэх эрх, иргэний нийгэм, иргэний орон зайн хувьд цөөнгүй тулгамдсан асуудал үүсээд байгаа бөгөөд төрөөс хараат бус, бие даан үйл ажиллагаа явуулах боломж хумигдаж, сайн дураараа эвлэлдэн нэгдсэн албан болон албан бус бүлгүүдийг үгүйсгэх байдал илэрч байна. Төр иргэний нийгмийн хамтын ажиллагаа, хөгжлийн бодлого, эрх зүйн орчин бүрдээгүйгээс ашгийн төлөө бус хуулийн этгээдийн чадавх, хөгжил бүрэн хэмжээнд хүрч, нээлттэй ил тод үйл ажиллагааг явуулж, нийгмийн үр нөлөө, капиталыг үр дүнтэй удирдан чиглүүлэх боломжгүй байна.
---	--

Энэ үүрэг амлалтыг тодорхойлно уу.	Иргэний орон зай, иргэний нийгмийн суурь зарчим, үнэт зүйлсийг багтаасан Төр, иргэний нийгмийн түншлэлийг хөгжүүлэх бодлого/үзэл баримтлалыг гаргах, Нийтэд
------------------------------------	---

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

	тустай үйл ажиллагаа, ашгийн бус хуулийн этгээд(холбоо, сан)-ийн талаарх эрх зүйн зохицуулалт нь хуулийн хүрээнд нээлттэй ил тод явуулах нөхцөл бололцоогоор хангах
Олон нийтэд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд энэ үүрэг амлалт нь хэрхэн хувь нэмэр оруулах вэ?	Төрийн бус байгууллагын эрх зүйг орчныг оновчтой тодорхойлох, зохицуулах боломж бүрдсэнээр иргэний нийгмийн төрөөс хараат бус ажиллах боломжийг бүрдүүлэх, нийтэд тустай ашгийн бус үйл ажиллагаа өргөжин тэлэх нөхцөл бүрдэнэ.
Энэ үүрэг амлалт нь яагаад НЗТ-ийн үнэт [эрхэмлэх] зүйлсэд хамааралтай вэ?	<ul style="list-style-type: none"> • Энэ үүрэг амлалтын хүрээнд ашгийн бус байгууллагын бүртгэл, мэдээллийн сан боловсронгуй болж, нээлттэй өгөгдөл бий болно. - Ил тод [нэвт тунгалаг] байдлын асуудалд уялдан хамаарна. • Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих хууль тогтоомж боловсруулж батлуулах, нээлттэй өгөгдлийн сан бий болгох зэрэг нь Иргэний оролцооны асуудалд уялдан хамаарна. • Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн эрх зүйн орчныг боловсронгуй болгосноор иргэд олон нийтийн байгууллага байгуулах, сайн дураар эвлэлдэн нэгдэх, төрөөс хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах, улмаар бодлого, шийдвэрийн төсөл боловсруулахад дуу хоолойгоо хүргэх, оролцох, хяналт тавих боломжийг нэмэгдүүлнэ.
Нэмэлт өгөгдөл мэдээлэл	<p>Дурдсан үүрэг амлалт нь дараах бодлогын болон хууль эрх зүйн баримт бичигтэй уялдсан болно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Монгол Улсын Үндсэн хуулийн Хүний эрх, эрх чөлөө хэмээх Хоёрдугаар бүлгийн Арван зургадугаар зүйлийн 10-т Монгол Улсын иргэн нь “Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс ... олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. ... олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. ... олон нийтийн бусад байгууллагад

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

	<p>эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно” хэмээн заасантай;</p> <ul style="list-style-type: none">• Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын⁵ 22 дугаар зүйлд “Хүн бүр бусадтай эвлэлдэн нэгдэх, түүний дотор өөрийн эрх ашгийг хамгаалах үүднээс үйлдвэрчний эвлэл байгуулах буюу түүнд элсэх эрхтэй” хэмээн иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх нь улс төрийн болон нийгэм соёлын бусад эрхээ эдлэх,⁶ хамтдаа улс орны хөгжлийн үйл явцад оролцох боломжийг хангахад чухал нөлөөтэй болохыг тодотгосонтой;• Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 58, 59 дүгээр заалттай;• Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын⁷ 3.3-т “Хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёс, монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшлийг дэмжиж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн.”, “... аж ахуйн шинжтэй чиг үүргүүдийг иргэний нийгмийн байгууллагаар... гүйцэтгүүлэх бодлого баримтална.”⁸, “Төрийн бодлого боловсруулах, төрд хяналт тавихад төрийн бус байгууллагын тэгш оролцоо, зөвшилцлийг хангах замаар иргэний нийгмийн төлөвшлийг дэмжинэ. Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлж, төр-иргэний нийгмийн хамтын
--	---

⁵ Монгол Улс 1968.01.05-нд гарын үсэгзүрж, 1974.11.18-нд соерхон баталсан.

⁶ Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын 22 дугаар зүйлийн 9-д “шууд болон төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй”, 12-т “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй”, 16-д “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөтэй”, 17-д “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нүүцэд хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй”.

⁷ Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт.

⁸ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3.2.5 дахь заалт.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

	ажиллагааны бүтээлч арга, хэлбэрүүдийг хөгжүүлнэ” ⁹ гэж заасан.	
Хүрэх үр дүнгийн тодорхойлолт	Иргэний орон зай, иргэний нийгмийн суурь зарчим, үнэт зүйлсийг агуулсан Төр, иргэний нийгмийн түншлэлийг хөгжүүлэх бодлогын баримт бичигтэй болсон байна. Түүнчлэн иргэд сайн дураар эвлэлдэн нэгдэж ашгийн төлөө бус байгууллага байгуулах, төрөөс хараат бусаар нээлттэй, ил тод, хариуцлагатайгаар үйл ажиллагаагаа явуулах, улмаар төрийн бодлого, шийдвэрийн төслийг боловсруулах, батлуулахад оролцох, хэрэгжилтэнд хяналт тавих, тодорхой бүлгийн эрх ашгийг хамгаалах боломжийг нэмэгдүүлсэн эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.	
Биелэлтийн дараа авах арга хэмжээ/алхамууд	Шинэчлэгдсэн хууль тогтоомжийг таниулах, сурталчлах	
Хүрэх үе шатуудын [майлстоун] хэрэгжилтийн байдал	Эхлэх огноо:	Дуусгах огноо:
Иргэдийн эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо, илэрхийлэх иргэний нийгмийн төрөөс хараат бус ажиллах орон зайг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх	2021.10.01	2022.12.25
Иргэний нийгмийн суурь зарчим, үнэт зүйлсийг багтаасан Төр, иргэний нийгмийн түншлэлийг хөгжүүлэх бодлогын баримт бичгийг боловсруулж, батлуулах үйл ажиллагааг нээлттэй ил тод иргэн, ИНБ-ийн оролцоог хангуулах	2021.12.01	2023.12.31
Иргэний нийгмийн байгууллагын бүртгэлийн журмыг хялбаршуулж, цахим бүртгэлийн системийг нэвтрүүлэх	2022.01.01	2023.01.01
Иргэний нийгмийн байгууллагын нээлттэй ил тод байдлыг бий болгох хүрээнд мэдээллийн цахим санг үүсгэн ажиллуулах	2022.01.01	2023.01.01

⁹ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.3.4.2 дахь заалт.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

Холбоо барих өгөгдөл мэдээлэл			
Манлайлж хариуцан хэрэгжүүлэх байгууллага		Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар Хууль зүй, дотоод хэргийн яам	
Хэрэгжүүлэгч байгууллагын хариуцсан ажилтан		Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг 88110079	
Албан тушаал, Газар, хэлтсийн нэр		Хууль зүйн бодлогын газрын шинжээч Н.Жамъянхүү	
Цахим шуудангийн хаяг, суурин болон гар утасны дугаар		jamiyankhuu@mojha.gov.mn 51+261935 (976) 99187051	
Бусад оролцогч талууд	Засгийн газрын яам, агентлаг: Иргэний нийгмийн байгууллага, Хувийн хэвшил, Олон талт байгууллага, Үндэсний хороо, Ажлын хэсэг	ХЗДХЯ, УБЕГ Иргэний нийгмийг дэмжих зөвлөл Иргэний нийгмийн консерциум Хүний эрхийн ТББ-ын Форум	
Нэмэлт өгөгдөл, мэдээлэл:			

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

Зорилт-5: Нийтийн сонсголын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтэд хөндлөнгийн оролцоог хангах, хяналтыг сайжруулах	
Хэрэгжих хугацаа: 2021– 2023	
Манлайлж хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хууль зүй, дотоод хэргийн яам Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар
Үүрэг амлалтын тодорхойлолт	
Энэхүү үүрэг амлалтаар олон нийтэд тулгамдаж буй ямар асуудлыг шийдвэрлэх вэ?	Төрийн бүх шатны байгууллага нь аливаа асуудлыг иргэд болон эрх ашиг нь хөндөгдөж буй талуудтай хэлэлцэн, бодитоор зөвшилцсөний дараа шийдвэрлэх төрийн хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх эрх зүйн орчин бүрдэж Нийтийн сонсголын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хууль тогтоомжийн тухай хууль батлагдсан хэдий ч талуудын оролцоог хангаагүй, оролцуулдаггүй, шийдвэрийг гэнэт гаргасны улмаас иргэд, олон нийтэд эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, сэтгэл санаагаар хохирох явдал түгээмэл байна. Түүнчлэн Хог хаягдлын тухай хууль батлагдаж, шинэ менежмент зохицуулалт хийгдсэн боловч хэрэгжилт хангалтгүй, суурин газрын иргэдийн эрүүл, авулгүй орчинд амьдрах эрх хангагдахгүй байна.
Энэ үүрэг амлалтыг тодорхойлно уу.	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын баталсан захиргааны хэм хэмжээний актыг бусад субъектыг баталсан захиргааны хэм хэмжээний акттай ижил хугацаанд хянаж, бүртгэх эрх бүхий байгууллагад хүргүүлэхээр Захиргааны ерөнхий хуульд заасан нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуульд заасан Засаг дарга иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрт хориг тавих эрхийг хязгаарласан, мөн хугацаатай уялдаагүй байх тул үүнийг хуульд нийцүүлэн өөрчлөх, хууль биелүүлээгүй бол зохих арга хэмжээ авах

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

<p>Олон нийтэд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд энэ үүрэг амлалт нь хэрхэн хувь нэмэр оруулах вэ?</p>	<p>1/ Захиргааны ерөнхий хууль болон бусад хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчил арилж, хуулийг нэг мөр ойлгож, хэрэглэх боломж бүрдэнэ.</p> <p>Нийтийн сонсголын тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийгдсэнээр төрийн шийдвэр гаргах шат тус бүрт иргэд, хүн амын бүлгүүд, эрх нь хөндөгдөж буй талуудад бодит мэдээлэл харилцан солилцох, иргэдийн шийдвэр гаргах үйл явцад оролцох оролцоо нэмэгдэнэ.</p> <p>Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийгдсэнээр хот, аймагт хог хаягдлаас үүсэх агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах</p>
<p>Энэ үүрэг амлалт нь яагаад НЗТ-ийн үнэт [эрхэмлэх] зүйлсэд хамааралтай вэ?</p>	<p>Ил тод [нэвт тунгалаг] байдал</p> <p>Үүрэг амлалт нь иргэн, хуулийн этгээдэд ээлтэй, хариуцлагатай захиргаатай байх төрийн зорилгыг хангахад эерэг нөлөө үзүүлж, иргэн, хуулийн этгээдийн захиргааны байгууллагад өргөдөл, гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэх, түүнийгээ шуурхай шийдвэрлүүлэх эрх хангагдана.</p> <p>●Иргэний оролцоо</p> <p>Үүрэг амлалт нь Өргөдөл, гомдлын ойлголтыг ялгаж тодорхойлсон нь иргэн, хуулийн этгээд нь захиргааны байгууллагад өргөдөл, гомдол гаргахад илүү ойлгомжтой болж, түүнийг шийдвэрлүүлэх журам тодорхой болж өгнө.</p> <p>●Төр засгийн хариуцлагыг сайжруулах</p> <p>Үүрэг амлалт нь Хууль хоорондын давхардлаас улбаалан захиргааны байгууллага иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажиллагааг хийдүүлдэг нөхцөл байдал арилна.</p>
<p>Нэмэлт өгөгдөл мэдээлэл</p>	<p>Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын Тав дахь зорилтод “Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний</p>

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

	эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.” гэж заасан.	
Хүрэх үр дүнгийн тодорхойлолт	Нийтийн сонсголын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилт, үр нөлөөнд хяналт үнэлгээ хийгдэж, төрийн болон холбогдох талуудад танилцуулагдаж, сайжруулах үйл ажиллагааны төлөвлөлт гарсан байна.	
Биелэлтийн дараа авах арга хэмжээ/алхамууд	Шинэчлэгдсэн хууль тогтоомжийг таниулах, сурталчлах	
Хүрэх үе шатуудын [майлстоун] хэрэгжилтийн байдал	Эхлэх огноо:	Дуусгах огноо:
Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтэд үр дүнгийн хөндлөнгийн хяналт үнэлгээ хийлгэх	2022.01.25	2022.03.25
Нийтийн сонсголын тухай хуулийн хэрэгжилтэд Хууль тогтоомжийн хуульд заасан хяналт үнэлгээ хийх	2022.01.25	2022.03.25
Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтэд Хууль тогтоомжийн хуульд заасан хяналт үнэлгээ хийх	2022.01.25	2022.03.25
Хяналт үнэлгээний дүнг нийтэд болон шийдвэр гаргагч нарт танилцуулж, сайжруулах арга хэмжээний төсөл боловсруулах	2022.03.25	2022.05.30
Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах	2022.04.25	2022.05.25
Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх.	2022.05.25	2022.06.01

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.		2022.06.05	2022.07.25
Шинэчлэгдсэн хууль тогтоомжийг таниулах, сурталчлах		2023.04.01	2023.06.30
Холбоо барих өгөгдөл мэдээлэл			
Манлайлж хариуцан хэрэгжүүлэх байгууллага		Хууль зүй, дотоод хэргийн яам Байгаль орчин аялал жуулчлалын яам	
Хэрэгжүүлэгч байгууллагын хариуцсан ажилтан		Хууль зүйн бодлогын газрын дарга П.Санзориг 88110079	
Албан тушаал, Газар, хэлтсийн нэр		Хууль зүйн бодлогын газрын шинжээч Н.Жамъянхүү	
Цахим шуудангийн хаяг, суурин болон гар утасны дугаар		jamiyankhuu@mojha.gov.mn 51+261935 (976) 99187051	
Бусад оролцогч талууд	Засгийн газрын яам, агентлаг: Иргэний нийгмийн байгууллага, Хувийн хэвшил, Олон талт байгууллага, Үндэсний хороо, Ажлын хэсэг	2/ Захиргааны байгууллагууд ХБНГУ-ын Ханнс Зайделийн сан Иргэний нийгмийн байгууллагууд	
Нэмэлт өгөгдөл, мэдээлэл:			

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

Зорилт-6: Улсын төсөв, төсвийн хөрөнгө оруулалтад иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх	
Хэрэгжих хугацаа: 2021-2023	
Манлайлж хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Сангийн яам, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар, Төсвийн хөрөнгө оруулалтын газар, Төрийн сангийн газар
Үүрэг амлалтын тодорхойлолт	
Энэхүү үүрэг амлалтаар олон нийтэд тулгамдаж буй ямар асуудлыг шийдвэрлэх вэ?	<p>Монгол Улсад Ковид-19 цар тахлын нөлөөгөөр ядуурал нэмэгдсээр, эдийн засгийн эрх чөлөө хумигдаж байна. Ядуурлын түвшнийг бууруулахад төсвийн бодлого чухал нөлөөтэй. Монгол Улсын Төсвийн тухай хуульд “Төсвийг төлөвлөн, баталж, хэрэгжүүлэхдээ төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангах; санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх; ил тод байдлыг ханган, хариуцлагатай байх” гэсэн зарчмуудын хэрэгжилтэд сайжруулах шаардлагатай байна. Үүний нэг жишээ нь төсвийн хөрөнгө оруулалтын зарим төсөл төлөвлөгдсөн хугацаандаа хэрэгжихгүй удаашрах, улмаар төсөвт өртөг нь жилээс жилд нэмэгдэн төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг буурч байна.</p> <p>Иймд төсвийн төлөвлөлтийн баримт бичгийн агуулгын иж бүрдэлд тавигдах шаардлагыг боловсронгуй болгох хэрэгтэй байна. Засгийн газраас боловсруулсан төсвийн хөрөнгө оруулалтын төслийн жагсаалтад зөвхөн тухайн жилийн санхүүжилтийг мөнгөн дүнгээр илэрхийлсэн мэдээлэл л тусгахаас шинэ төслийн нийт төсөвт өртгийн хэдэн хувийг эхний жилд төлөвлөж буйгаа харуулдаггүй. Энэ нь тухайн төслийн төлөвлөлт хуульд нийцсэн эсэхийг хууль тогтоогчид шууд харах боломжгүй болгодог. Түүнчлэн шилжих төслүүдийн хувьд зөвхөн өргөн барьж буй төсөлд туссан төсөвт өртгийг л тусгаснаас тухайн төслийн анх батлагдсан төсөвт өртгийн мэдээлэл багтаагүй байна. Гэтэл зарим шилжих төслийн анх батлагдсан төсөвт өртөг ихээхэн нэмэгдэж байна. Ийнхүү хөрөнгө оруулалтын шинэ болон шилжих төслүүдийн мэдээллийн иж бүрдэл хангалтгүй байгаа нь УИХ-ын гишүүд бүрэн мэдээлэлтэйгээр шийдвэр гаргах боломжийг хязгаарлаж, иргэдэд хүрэх мэдээллийн иж бүрэн байдал хангагдахгүй байна.</p> <p>Монгол Улсын Их Хурлаас батлагдсан төсвийн мэдээллийн</p>

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

	<p>иж бүрдэл сул байгаа нь Олон улсын төсвийн түншлэлийн “Төсвийн нээлттэй байдал” судалгааны дүнгээс харагдаж байна. Тухайлбал, агуулгын иж бүрэн байдлаар авбал зохих 100 онооноос батлагдсан төсөв 30 хувийг авчээ. Олон улсын сайн туршлагатай харьцуулахад манай улс батлагдсан төсөвтөө зарлагыг эдийн засгийн ангиллаар, зориулалтаар болон хөтөлбөрөөр ангилсан мэдээлэл болон орлогыг эх үүсвэрээр ангилсан байдлаарх мэдээллийг тусгадаггүй байна. Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлд төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөн, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнахаар заасан. Батлагдсан төсвийн ямар мэдээллийг хэрхэн олон нийтэд хүргэх тухай нарийвчилсан зохицуулалтыг бий болгох нь дээр дурдсан асуудлыг шийдвэрлэх нэг гарц юм.</p> <p>Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг мэдээллийн нээлттэй өгөгдлийн сангийн олон улсын стандартын шаардлага хангахуйц түвшинд өөрчлөн, шинэчилж, боловсронгуй болгох, иргэд, олон нийт ил тод байршуулсан мэдээллийг татан авч дүн шинжилгээ хийхэд хялбаршуулж, хөгжүүлэх ажлыг хийж дуусгах шаардлагатай байна. Цаашилбал, улсын төсвийн төлөвлөлт, зарцуулалтын талаар иргэд, олон нийт, татвар төлөгчид жилийн турш саналаа өгч хэлэлцүүлэг өрнүүлж байх цахим талбарыг одоо ашиглаж буй цахим платформууд дээр тулгуурлан бий болгох.</p>
<p>Энэ үүрэг амлалтыг тодорхойлно уу.</p>	<p>Улсын төсөв, төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийн ил тод байдал, хүртээмж, иргэдийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх хүрээнд дараах амлалтуудыг авч байна. Үүнд:</p> <p>1. Төсвийн үйл явцын мэдээллийн ил тод, шуурхай бөгөөд иж бүрэн байдлыг хангах зохицуулалтуудыг төсвийн хууль тогтоомжинд оруулах</p> <p>Энэ хүрээнд Монгол Улсын улсын төсөв, хөрөнгө оруулалт, тусгай сангууд, зээл тусламж, төсөл хөтөлбөрийн төлөвлөлтөөс эхлээд хэрэгжүүлж дуусах бүхий л үйл явцын мэдээллийн ил тод, шуурхай бөгөөд иж бүрэн байдлыг хангах зохицуулалтыг НЗТ-ийн Үндэсний 4-р төлөвлөгөөний хугацаанд төсвийн хууль тогтоомжинд оруулах, үүний тулд одоо байгаа зохицуулалтад дүн шинжилгээ хийж, тэдгээрийн хэрхэн боловсронгуй болгох санал боловсруулах үүрэг бүхий зөвлөлдөх механизмыг талуудын оролцоотойгоор ажиллуулж үр дүнд хүргэх.</p>

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

	<p>2. Шилэн дансны нэгдсэн системийг НЗТ-ийн Үндэсний 4-р төлөвлөгөө хэрэгжих хугацаанд иж бүрэн шинэчлэх. Энэ хүрээнд Шилэн дансны системийг нээлттэй өгөгдлийн зарчмаар шинэчлэх; Шилэн дансны систем ямар байх талаар олон нийтийн хэлэлцүүлэг хийх. shilendans.gov.mn сайтыг шинэчлэхдээ төсвийн хэрэгжилт, ил тод байдлыг хангахад ашиглагдаж буй систем хоорондын уялдааг хангах, талуудын оролцоог тэгш хангаж санал солилцох, судалгаан дээр тулгуурлан хөгжүүлэх.</p> <p>3. Улсын төсвийн үйл явц, хөрөнгө оруулалт, зарцуулалт тусгай сангууд, гадаадын зээл тусламжийн зарцуулалтын талаар иргэд, олон нийт, татвар төлөгчид жилийн турш саналаа өгч хэлэлцүүлэг өрнүүлж байх цахим талбарыг бий болгох Энэ хүрээнд улсын төсвийн төлөвлөгөө, зарцуулалтад олон нийт, татвар төлөгчид жилийн турш саналаа өгч хэлэлцүүлэг өрнүүлж байх цахим талбарыг төсвийн ил тод байдлын цахим хуудсанд бий болгоно. Мөн Төсвийн хөрөнгө оруулалтын publicinvestment.gov.mn сайт дах хайлтын системд төслийг “эхлэх огноо”-гоор нь хайлт хийх сонголт оруулна.</p>
<p>Олон нийтэд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд энэ үүрэг амлалт нь хэрхэн хувь нэмэр оруулах вэ?</p>	<p>Эдгээр амлалт нь улсын төсөв, хөрөнгө оруулалтын төслүүдийн мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэдийн оролцоо, хяналтыг бий болгон төсвийн зарлагын үр ашгийг нэмэгдүүлж, төсвийн удирдлагыг сайжруулах, Олон улсын төсвийн түншлэл байгууллагаас хийдэг Төсвийн нээлттэй байдлын индекс сайжрах, Авлигын индексийг бууруулахад эерэг нөлөө үзүүлнэ.</p>
<p>Энэ үүрэг амлалт нь яагаад НЗТ-ийн үнэт [эрхэмлэх] зүйлсэд хамааралтай вэ?</p>	<ul style="list-style-type: none"> - Ил тод, нээлттэй байдал - Хариуцлагатай байдал - Иргэдийн оролцоо
<p>Нэмэлт өгөгдөл мэдээлэл</p>	<p>1.Монгол Улсын хөгжлийн алсын хараа-2050 (Бүлэг 5: Зорилт 5.1.20)</p>

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

	<p>2. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр (Зүйл 3.1.12, 4.1.8)</p> <p>3. Монгол Улсын Их хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөө, алсын хараа (<i>Стратегийн зорилт 2.2: 2.2.5, 2.2.7; Стратегийн зорилт 3.1: 3.1.12; Стратегийн зорилт 3.2: 3.2.1; Стратегийн зорилт 6.1: 6.1.3</i>)</p> <p>4. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (Бүлэг 3: 4.1.3.1, 4.1.3.2, 4.1.3.3, 4.1.3.4)</p>
<p>Хүрэх үр дүнгийн тодорхойлолт</p>	<p>1. Төсвийн үйл явцын мэдээллийн ил тод, шуурхай бөгөөд иж бүрэн байдлыг хангах зохицуулалтууд төсвийн хууль тогтоомжинд туссан байна.</p> <p>2. Шилэн дансны нэгдсэн систем нээлттэй өгөгдлийн зарчмаар иж бүрэн шинэчлэгдсэн байна.</p> <p>3. Улсын төсвийн үйл явц, хөрөнгө оруулалт, зарцуулалт тусгай сангууд, гадаадын зээл тусламжийн зарцуулалтын талаар иргэд, олон нийт, татвар төлөгчид жилийн турш саналаа өгч хэлэлцүүлэг өрнүүлж байх цахим талбар бий болсон байна.</p>
<p>Авах арга хэмжээ/алхамууд</p>	<p>1. Төсвийн үйл явцын мэдээллийн ил тод, шуурхай бөгөөд иж бүрэн байдлыг хангах зохицуулалтуудыг төсвийн хууль тогтоомжинд оруулах. Энэ хүрээнд Монгол Улсын улсын төсөв, хөрөнгө оруулалт, тусгай сангууд, зээл тусламж, төсөл хөтөлбөрийн төлөвлөлтөөс эхлээд хэрэгжүүлж дуусах бүхий л үйл явцын мэдээллийн ил тод, шуурхай бөгөөд иж бүрэн байдлыг хангах зохицуулалтыг НЗТ-ийн Үндэсний 4-р төлөвлөгөөний хугацаанд төсвийн хууль тогтоомжинд оруулах, үүний тулд одоо байгаа зохицуулалтад дүн шинжилгээ хийж, тэдгээрийн хэрхэн боловсронгуй болгох санал боловсруулах үүрэг бүхий зөвлөлдөх механизмыг талуудын оролцоотойгоор ажиллуулж үр дүнд хүргэх.</p> <p>Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн журамд дараах зохицуулалтуудыг нэмж тусгана: i) Улсын төсвийн хөрөнгөөр ирэх онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний маягтад шинээр эхлэх төслүүдийн хувьд “тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүнг нийт төсөвт өртөгт эзлэх хувиар”, шилжих төслүүдийн хувьд “анх батлагдсан төсөвт өртөг” гэсэн мэдээллүүдийг нэмэх; ii) Төсвийн тодотгол хийгдэх тохиолдолд УИХ-д өргөн баригдах хөрөнгө оруулалтын төслийн жагсаалтын тусгайлсан маягтуудыг боловсруулах.</p>

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

	<p>2. Шилэн дансны нэгдсэн системийг НЗТ-ийн Үндэсний 4-р төлөвлөгөө хэрэгжих хугацаанд иж бүрэн шинэчлэх.</p> <p>3. Улсын төсвийн үйл явц, хөрөнгө оруулалт, зарцуулалт тусгай сангууд, гадаадын зээл тусламжийн зарцуулалтын талаар иргэд, олон нийт, татвар төлөгчид жилийн турш саналаа өгч хэлэлцүүлэг өрнүүлж байх цахим талбарыг бий болгох.</p>	
Хүрэх үе шатуудын хэрэгжилтийн байдал	Эхлэх огноо:	Дуусгах огноо:
<p>Монгол Улсын улсын төсөв, хөрөнгө оруулалт, тусгай сангууд, зээл тусламж, төсөл хөтөлбөрийн төлөвлөлтөөс эхлээд хэрэгжүүлж дуусах бүхий л үйл явцын мэдээллийн ил тод, шуурхай бөгөөд иж бүрэн байдлыг хангах зохицуулалтыг төсвийн хууль тогтоомжинд оруулах, үүний тулд одоо байгаа зохицуулалтад дүн шинжилгээ хийж, тэдгээрийн хэрхэн боловсронгуй болгох санал боловсруулах үүрэг бүхий зөвлөлдөх механизмыг талуудын оролцоотойгоор ажиллуулж үр дүнд хүргэх</p>	2022.03.01	2022.12.31
<p>Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журамд батлагдсан төсвийн тоон мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар ил болгох зохицуулалт оруулах</p>	2022.06.30	2022.12.31
<p>shilendans.gov.mn сайтыг шинэчлэхдээ төсвийн хэрэгжилт, ил тод байдлыг хангахад ашиглагдаж буй систем хоорондын уялдааг хангах, талуудын оролцоог тэгш хангаж санал солилцох, судалгаан дээр тулгуурлан хөгжүүлэх</p>	2022.06.01	2023.02.30

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

Төсвийн төлөвлөлт, зарцуулалтад иргэд жилийн турш саналаа өгч болох цахим талбар бий болгох		2022.08.01	2023.03.31
Төсвийн төлөвлөлт, зарцуулалтад иргэд өгсөн саналыг хэрхэн шийдвэрлэсэн талаар иргэд цахим платформоос харах боломжтой болгох		2022.10.01	2023.03.31
Төсвийн хөрөнгө оруулалтын publicinvestment.gov.mn сайт дах хайлтын системд төслийг “эхлэх огноо”-гоор нь хайлт хийх сонголт оруулах.		2022.06.01	2023.03.31
Холбоо барих өгөгдөл мэдээлэл			
Манлайлж хариуцан хэрэгжүүлэх байгууллага		- Сангийн яам, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар, Төсвийн хөрөнгө оруулалтын газар, Төрийн сангийн газар	
Хэрэгжүүлэгч байгууллагын хариуцсан ажилтан		Сангийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Г.Золбоо zolboo_g@mof.gov.mn Утас-99196439	
Албан тушаал, Газар, хэлтсийн нэр		Бодлого, төлөвлөлтийн газрын төсвийн нэгтгэлийн хэлтсийн зөвлөх Б.Номин	
Цахим шуудангийн хаяг, суурин болон гар утасны дугаар		утас: 88022089, 264495	
Бусад оролцогч талууд	Засгийн газрын яам, агентлаг: Иргэний нийгмийн байгууллага, Хувийн хэвшил, Олон талт байгууллага,	УИХ-ын Төсвийн байнгын хороо, ЗГХЭГ, Үндэсний аудитын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Үндэсний хөгжлийн газар, ХЗДХЯ Нээлттэй нийгэм форум ТББ, Ил тод байдал сан ТББ, Үнэн хатамж ТББ	

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

	Үндэсний хороо, Ажлын хэсэг	
Нэмэлт өгөгдөл, мэдээлэл:		

Зорилт-7: Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт, чанар, аюулгүй байдал, ханган нийлүүлэлтийн ил тод байдал, хяналтыг сайжруулах

Хэрэгжих хугацаа: 2021-2023

Манлайлж хариуцан хэрэгжүүлэх байгууллага

Эрүүл мэндийн яам
Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар

Үүрэг амлалтын тодорхойлолт

Энэхүү үүрэг амлалтаар олон нийтэд тулгамдаж буй ямар асуудлыг шийдвэрлэх вэ?

“Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-ыг 2020-2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан “Хүн амыг чанартай, боломжийн үнэтэй эм, эмнэлгийн хэрэгслээр хангаж, зохистой хэрэглээг төлөвшүүлэх” зорилтын хүрээнд:

- Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлттэй үнээр олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг тогтоох;
- Эм зүйн салбарын эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх.

Энэ үүрэг амлалтыг тодорхойлно уу.

- Зайлшгүй шаардлагатай эмийг иргэдэд эрүүл мэндийн даатгалаар хөнгөлттэй, хүртээмжтэй олгох боломжийг нэмэгдүүлнэ.
- Эмийн бүртгэл мэдээлэлийн нэгдсэн цахим системийг нэвтрүүлж, мэдээллийн ил тод байдлыг сайжруулна гэж заасан байдаг.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

<p>Олон нийтэд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд энэ үүрэг амлалт нь хэрхэн хувь нэмэр оруулах вэ?</p>	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн даатгалаар хөнгөлттэй олгох эмийн жагсаалтыг тухай бүр батлан гаргаж, нийтэд нээлттэй мэдээллийг вэб сайт дээр байршуулна; • Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг шинэчлэн боловсруулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ; • Эрүүл мэндийн салбарын цахим мэдээллийн тогтолцоонд эмийн зохицуулалтын үйл ажиллагааг уялдуулан хөгжүүлснээр олон нийт эмийн талаарх мэдээллийг ил тод авах боломж бүрдэнэ.
<p>Энэ үүрэг амлалт нь яагаад НЗТ-ийн үнэт [эрхэмлэх] зүйлсэд хамааралтай вэ?</p>	<p>Ил тод [нэвт тунгалаг] байдал Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт болон эрүүл мэндийн даатгалаар хөнгөлттэй олгох эмийн үнэ ил тод болно;</p> <p>•Иргэний оролцоо Бүртгэлтэй эмийн жагсаалтыг Licemed программаар дамжуулан иргэдэд нээлттэй харах боломжтой болно;</p> <p>•Төр засгийн хариуцлагыг сайжруулах Эмийн зохистой хэрэглээний талаарх мэдээлэл ил тод явагдана.</p>
<p>Нэмэлт өгөгдөл мэдээлэл</p>	<ul style="list-style-type: none"> • Эм, эрүүл мэндийн хэрэглэгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгаар эмийн үнийг зохицуулна. <p><i>Үүрэг амлалтыг хэрэгжүүлэх төсөв:</i></p> <ul style="list-style-type: none"> • Улсын төсөв; • Эрүүл мэндийн даатгалын сан. <p><i>Засгийн газрын бусад хөтөлбөрүүдтэй уялдаж буй эсэх</i></p> <ul style="list-style-type: none"> • Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр; <p>Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, 2020-2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө.</p>
<p>Хүрэх үр дүнгийн тодорхойлолт</p>	<ul style="list-style-type: none"> • Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг шинэчлэн боловсруулж, үнийн дээд хэмжээг тогтоосон мэдээллийг байнга нээлттэй байршуулдаг болно. • Эрүүл мэндийн даатгалаар хөнгөлттэй олгох эмийн жагсаалтыг боловсруулахад ашиглах гадаад, дотоодын жишиг үнийг тогтоодог болсон байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

Биелэлтийн дараа авах арга хэмжээ/алхамууд	<ul style="list-style-type: none"> ● Эмийн зохистой хэрэглээний талаар олон нийтэд хүргэх мэдээллийн үндсэн агуулгыг боловсруулж, мэдээлэл, сурталчилгаа хийх; ● Эмийн үнийн эрх зүйн орчны үнэлгээг хийж, хууль эрх зүйн баримт бичигт үнийн зохицуулалтын талаар өөрчлөлт оруулах; ● Хөнгөлөлттэй үнээр олгох зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг боловсруулахад ашиглах гадаад, дотоодын жишиг үнийг тогтоодог болох; ● Эмийн зохицуулалтын болон Гаалийн ерөнхий газрын цахим мэдээний сангийн мэдээллийг ашигладаг болох. 	
Хүрэх үе шатуудын хэрэгжилтийн байдал	Эхлэх огноо:	Дуусгах огноо:
Эмийн зохистой хэрэглээний талаар олон нийтэд хүргэх мэдээллийн үндсэн агуулгыг боловсруулж, мэдээлэл, сурталчилгаа хийх	2022.01.01	2022.05.30
Эмийн үнийн эрх зүйн орчны үнэлгээг хийж, хууль эрх зүйн баримт бичигт үнийн зохицуулалтын талаар өөрчлөлт оруулах	2022.02.20	2023.11.30
Хөнгөлөлттэй үнээр олгох зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг боловсруулахад ашиглах гадаад, дотоодын жишиг үнийг тогтоодог болох	2022.06.30	2023.11.30
Эмийн зохицуулалтын болон Гаалийн ерөнхий газрын цахим мэдээний сангийн мэдээллийг ашигладаг болох	2022.06.30	2023.11.30
Холбоо барих өгөгдөл мэдээлэл		
Манлайлж хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Эрүүл мэндийн яам; Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	
Хэрэгжүүлэгч байгууллагын хариуцсан ажилтан	1. Б.Цэцэгсайхан; 2. Д.Пүрэвжав; 3. Ш.Энхтуяа	

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

Албан тушаал, Газар, хэлтсийн нэр		<ul style="list-style-type: none"> • Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын дарга; • Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эмийн аюулгүй байдал, тандалт судалгааны газрын дарга; • Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Чанарын хяналтын газрын дарга.
Цахим шуудангийн хаяг, суурин болон гар утасны дугаар		<p align="center">purevjav@mmra.gov.mn; enkhtuya@mmra.gov.mn; +(976) 88088119, (976) 99250976</p>
Бусад оролцогч талууд	Засгийн газрын яам, агентлаг: Иргэний нийгмийн байгууллага, Хувийн хэвшил, Олон талт байгууллага, Үндэсний хороо, Ажлын хэсэг	<p>ЭМДҮЗ СЯ, ХААХҮЯ, БСШУЯ, ХААГ, ГЕГ, МХЕГ, МЭЕГ, ХХГ, ТЕГ, Гааль, татвар, санхүү, мэдээллийн технологийн газар</p> <p>Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын нэгдсэн холбоо; Эм зүйн байгууллагуудын нэгдсэн “Эм” холбоо.</p>
Нэмэлт өгөгдөл, мэдээлэл:		

Зорилт-8: Хэвлэлийн эрх чөлөөг хангах эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх	
Хэрэгжих хугацаа: 2021-2023	
Манлайлж хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хууль зүй, дотоод хэргийн яам
Үүрэг амлалтын тодорхойлолт	

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

<p>Энэхүү үүрэг амлалтаар олон нийтэд тулгамдаж буй ямар асуудлыг шийдвэрлэх вэ?</p>	<p>Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, Зөрчлийн тухай хуульд хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан “илт худал мэдээллийг олон нийтэд тараасан” тохиолдолд хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан. Энэ нь “илт худал мэдээлэл” гэх хэт өргөн хүрээний, мэдээллийн гуйвуулга, тархалтын мөн чанарыг харгалзаагүй тодорхой бус нэр томъёо нь хуулийг хэтрүүлэн хэрэглэх, ялгаварлан гадуурхах, үзэмжээр шийдвэрлэх эрсдэлийг нэмж, иргэдийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах эрсдэлийг бий болгож байна.</p> <p>2020 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Өргөн нэвтрүүлгийн тухай хууль нь өргөн нэвтрүүлгийн хараат бус зохицуулалтыг баталгаажуулаагүй, тусгай зөвшөөрөл олгох, цуцлах эрх мэдлийг Засгийн газрын шууд мэдэлд үлдээсэн. Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн дагуу иргэд, олон нийтийг аливаа улс төр, бизнесийн ашиг сонирхлоос хараат бус мэдээллээр олон нийтийг хангах үүрэгтэй үндэсний хэмжээний өргөн нэвтрүүлгийн байгууллагыг бий болгосон. Гэвч ОНРТ-ийн тухай хуулийн зарим заалт болон түүний хэрэгжилтээс шалтгаалж иргэдийг хараат бус, тэнцвэртэй мэдээллээр хангах үүрэг хэрэгжихгүй байна. Сэтгүүлч нууц эх сурвалжаа хамгаалах эрхийг зөвхөн ОНРТ-ийн тухай хуульд тусгасан нь хэвлэл мэдээллийн бусад байгууллагад ажиллаж буй сэтгүүлчид нэн ялангуяа эрэн сурвалжилсан, зөрчил, хэргийг илрүүлсэн мэдээлэл түгээснийхээ төлөө эх сурвалжлаа шүүхийн өмнө ил болгох шаардлагыг бий болгож байна.</p>
--	---

<p>Энэ үүрэг амлалтыг тодорхойлно уу.</p>	<p>Хэвлэлийн эрх чөлөөг хангах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх зүйн орчныг бүрдүүлснээр дээр дурдсан хууль эрх зүйн зохицуулалтыг олон улсын эрх зүйн хэм хэмжээнд хүргэх, иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйл, түүний үзэл санаанд нийцүүлэх.</p>
<p>Олон нийтэд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд энэ үүрэг амлалт нь</p>	<ul style="list-style-type: none"> • Иргэдийн үзэл бодол, шаардлагын дагуу төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны ил тод байдал нэмэгдэнэ.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

<p>хэрхэн хувь нэмэр оруулах вэ?</p>	<ul style="list-style-type: none"> • Иргэдийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, сэтгүүлчдийн мэргэжлийн үүргээ хараат бусаар биелүүлэх эрх “илт худал мэдээлэл тараасан” гэх хуулийн заалтаар үндэслэлгүйгээр хязгаарлах эрсдэл багасна. • Олон нийтийн санаа бодол бүрэлдэхэд онцгой нөлөө бүхий өргөн нэвтрүүлгийн салбарт улс төрийн шууд нөлөөллийг хязгаарлах замаар иргэдийн олон ургалч эх сурвалжаас чанартай мэдээлэл хүртэх эрхийн хэрэгжилт сайжирна. • Хэвлэл мэдээллийн эзэмшигчдийн ил тод байдлыг сайжруулснаар хэвлэл мэдээллийн агуулгад нөлөөлж буй ашиг сонирхлын зөрчлийг ил болгож, улмаар иргэдийн мэдэх эрхийн хэрэгжилт дээшилнэ. <p>Хэвлэл мэдээллийн салбарт хэт төвлөрлөөс хамгаалах зохицуулалтыг илүү тодорхой, үр дүнтэй болгосноор хэвлэл мэдээллийн олон ургалч байдал, иргэдийн олон талт мэдээллийн эх сурвалжийг бодит болох.</p>
<p>Энэ үүрэг амлалт нь яагаад НЗТ-ийн үнэт [эрхэмлэх] зүйлсэд хамааралтай вэ?</p>	<ul style="list-style-type: none"> • Ил тод байдал Үүрэг амлалт олон нийтэд мэдээллийн ил тод байдал, хүртээмж, олон ургалч мэдээллийн эх үүсвэрийг баталгаажуулж, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангана. • Иргэний оролцоо Үүрэг амлалт нь төр засгийн шийдвэр гаргалтын талаар олон нийт мэдээлэл авах, түүнд нөлөөлөх боломж чадамжийг сайжруулна. • Төр засгийн хариуцлагыг сайжруулах Үүрэг амлалт нь төрийн албан тушаалтнууд үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээлгэхэд шаардлагатай мэдээллийг ил тод болгоно.
<p>Нэмэлт өгөгдөл мэдээлэл</p>	<p>- Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолын хавсралт “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 5.2.5-д “улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг шалгах, мэдээлэгчийг хамгаалахад иргэн хяналт тавих бололцоо</p>

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

	<p>бүрдсэн байх” гэж тусгаж, түүнийг хөтөлбөрийг хэрэгжүүлэх хоёр дахь үе шатанд /2020-2023 он/ хамааруулжээ.</p> <p>- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 5.6.5-д “Авлига, албан тушаалын гэмт хэргийн мэдээлэл хүлээн авах, нууцыг хадгалах тогтолцоог бэхжүүлж, энэ төрлийн гэмт хэргийг илчилсэн, мэдээлсэн хүнийг хамгаалах эрх зүйн үндсийг бүрдүүлж, авлигаас урьдчилан сэргийлэх төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, олон нийтийн хяналтыг сайжруулна” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралт “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 92-т “Шүгэл үлээгчийг хамгаалах тухай” хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Авлигатай тэмцэх газар хамтран боловсруулж, Засгийн газар өргөн барихаар заасан. Ингэхдээ хуулийн төслийг өргөн мэдүүлэх хугацааг “2023” он гэж, хууль тогтоомжийн төсөл боловсруулах үндэслэл, зохицуулах харилцааны товч утгыг “Төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг шүүмжилсэн, мэдээлсэн, илчилсэн тохиолдолд яллах, эрүүгийн хариуцлагад татах, дарамтлахаас мэдээлэгчийг хамгаалах, шүгэл үлээгчдийг аливаа өш хонзон, гэмт хэргийн хохирогч болохоос хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох” гэж тус тус тусгажээ.</p> <p>- НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдаж буй байдал:</p> <p>“Тогтвортой хөгжлийн төлөө аюулгүй, бүх талын оролцоог хангасан нийгмийг хөгжүүлж, хүн бүрийг хуулиар хамгаалуулах боломжоор хангах, бүх түвшинд үр дүнтэй, хариуцлагатай, бүх талын оролцоог хангасан институтийг бий болгох” 16 дугаар зорилтын Зорилт 16.5 /Авлига, хээл хахуулийн бүх хэлбэрийг үлэмж хэмжээгээр багасгах/, Зорилт 16.6 /Бүх түвшинд үр дүнтэй, хариуцлагатай, ил тод үйл ажиллагаатай институтийг хэвшүүлэх/, Зорилт 16.7 /Бүх түвшинд хурдан шуурхай, бүх талын оролцоог хангасан, оролцооны аргад тулгуурласан, төлөөллийн шийдвэр гаргадаг болох/, Зорилт 16.10 /Үндэсний хууль тогтоомж</p>
--	--

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

	болон олон улсын гэрээ хэлэлцээрт нийцүүлэн олон нийтийг мэдээлэл олж авах боломжоор хангах, үндсэн эрх чөлөөг хамгаалах/	
Хүрэх үр дүнгийн тодорхойлолт	Олон нийт хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгслээс тэнцвэртэй, бодитой мэдээлэл авах, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах	
Биелэлтийн дараа авах арга хэмжээ/алхамууд	<ul style="list-style-type: none"> • Хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийн тухай олон нийтэд сурталчлан таниулах • Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор холбогдох төрийн байгууллагын ажилтнуудад сургалт, мэдээллийн үйл ажиллагаа • Хуулийн хэрэгжилтийг хянах хараат бус мониторингийн үйл ажиллагаа 	
Хүрэх үе шатуудын [майлстоун] хэрэгжилтийн байдал	Эхлэх огноо:	Дуусгах огноо:
1. Үүрэг амлалтын хэрэгжилтийг хангах ажлын хэсэг байгуулах	2021.12.1	2022.3.15
2. Үүрэг амлалтад дурдсан хууль эрх зүйн зохицуулалтад үнэлгээ хийх, үр дүн оролцогч талуудад танилцуулах	2021.12.15	2022.3.15
3. Үүрэг амлалтад дурдсан хууль эрх зүйн зохицуулалтыг сайжруулах олон улсын хэм хэмжээг судлах, нэмэлт өөрчлөлтийн санал боловсруулах	2022. 2.15	2022.5.15
4. Холбогдох хуулийн нэмэлт өөрчлөлтөд иргэд, олон нийт, оролцогч талуудын санал авах	2022. 5.15	2022.7.15
5. Хууль оруулах нэмэлт өөрчлөлтийг эцэслэн боловсруулж өргөн барих. Лобби үйл ажиллагаа зохион байгуулах	2022.7.15	2022.9.15
Сэтгүүлч эх сурвалжаа нууцлах баталгааг Шүгэл үлээгчийг хамгаалах тухай болон Хэвлэл	2022.7.15	2022.9.15

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлд тусгах.			
Төрийн болон албаны нууцын тухай хуулийг өөрчилж, Засгийн газрын тогтоол, төрийн байгууллагын шийдвэрээр бус зөвхөн хуулиар төрийн нууцын жагсаалтыг батлах.		2022.7.15	2022.9.15
Холбоо барих өгөгдөл мэдээлэл			
Манлайлж хариуцан хэрэгжүүлэх байгууллага		ХЗДХЯ	
Хэрэгжүүлэгч байгууллагын хариуцсан ажилтан		Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг	
Албан тушаал, Газар, хэлтсийн нэр		Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Ж.Амгалан	
Цахим шуудангийн хаяг, суурин болон гар утасны дугаар		sainzorig@mojha.gov.mn утас: 261957	
Бусад оролцогч талууд	Засгийн газрын яам, агентлаг: Иргэний нийгмийн байгууллага, Хувийн хэвшил, Олон талт байгууллага, Үндэсний хороо, Ажлын хэсэг	<ul style="list-style-type: none"> - Хүний эрхийн Үндэсний Комисс - Хэвлэл мэдээллийн зөвлөл - Хэвлэлийн хүрээлэн - Глоб Интернэшнл Төв - Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл - “Цахим засаглалд шилжих, хүнд суртал, авлигагүй төрийн үйлчилгээг бүрдүүлэх” үндэсний хороо - Тогтвортой хөгжлийн үндэсний хороо “Иргэдийн оролцоо” төсөл 	
Нэмэлт өгөгдөл, мэдээлэл:			

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

Зорилт-9: Төрийн үйлчилгээг цахимжуулж, төрийн үйлчилгээг хүртээмжтэй болгох	
Хэрэгжих хугацаа: 2021-2023	
Манлайлж хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Засгийн газрын тохируулагч агентлаг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар
Үүрэг амлалтын тодорхойлолт	
Энэхүү үүрэг амлалтаар олон нийтэд тулгамдаж буй ямар асуудлыг шийдвэрлэх вэ?	<ul style="list-style-type: none"> ● Иргэд, бизнес эрхлэгчдийн авдаг төрийн үйлчилгээг хүртээмжтэй, түргэн шуурхай, чирэгдэлгүй, хүнд сурталгүй, ил тод хүргэх ● Алслагдсан орон нутгийн иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй, харааны бэрхшээлтэй иргэд, ахмадууд, малчид зэрэг хүмүүсийн дунд цахим сүлжээ хэрэглээ болж чадахгүй, тэгш бус байдлыг үүсгээд байна. ● Харилцан ялгаатай чиг үүрэг бүхий олон төрлийн төрийн байгууллагуудын зохион байгуулалтыг сайжруулах, үйл ажиллагааны зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх
Энэ үүрэг амлалтыг тодорхойлно уу.	<ul style="list-style-type: none"> ● Төрийн үйлчилгээний нэгдсэн систем “eMongolia”-аар үзүүлэх төрийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, илүү хялбар болж төрийн үйлчилгээний хүнд суртал, шат дамжлага бусад хүндрэлийн талаар мэдээлэл авах цахим цонх ажиллана. Хиймэл оюун ухаанд суурилсан технологи ашиглан иргэдэд төрөл бүрийн мэдээлэл, мэдэгдэл хүргэх нэгдсэн платформ хөгжүүлж нэвтрүүлнэ.
Олон нийтэд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд энэ үүрэг амлалт нь хэрхэн хувь нэмэр оруулах вэ?	<ul style="list-style-type: none"> ● Төрийн үйлчилгээний нэгдсэн систем “eMongolia”-аар үзүүлэх төрийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх 2022 онд 30 үйлчилгээ, 2023 онд 20 үйлчилгээ нэмэх, хэрэглээг илүү хялбар болгоно. ● Иргэн, хуулийн этгээд төрийн үйлчилгээ авахад учирдаг хүнд суртал, саад бэрхшээлийг иргэдийн санал хүсэлтийн дагуу тодорхойлон цахим хэлбэрт шилжүүлнэ.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

	<ul style="list-style-type: none"> • Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээ, шийдвэрийн талаарх мэдээлэл цаг алдалгүй хүрнэ. • Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах, түүний хариуг цаг, цаас үрэхгүй авах боломж бүрдэнэ. • Иргэд, аж ахуйн нэгж төрийн үйлчилгээний талаарх үнэн зөв мэдээллийг хүндрэлгүй, шуурхай авах боломжтой болно. • Төрийн үйлчилгээний цахим сайт, аппликейшнүүд нэгдсэн стандарттай, иргэдэд хүртээмжтэй болно.
<p>Энэ үүрэг амлалт нь яагаад НЗТ-ийн үнэт [эрхэмлэх] зүйлсэд хамааралтай вэ?</p>	<p>Ил тод [нэвт тунгалаг] байдал</p> <ul style="list-style-type: none"> • Үүрэг амлалт нь илүү их өгөгдөл мэдээллийг ил нээлттэй болгож хэрэглээг нэмэгдүүлнэ. Мөн ил нээлттэй байгаа өгөгдөл мэдээллийн чанарыг сайжруулаж олон нийтэд өгөгдөл мэдээллийн хүртээмж хүртцийг нэмэгдүүлэх, хэрэглээг илүү хялбар болгоно. <p>•Иргэний оролцоо</p> <ul style="list-style-type: none"> • Үүрэг амлалт нь төр засгийн шийдвэр гаргалтын талаар олон нийт мэдээлэл авах буюу түүнд нөлөөлөх боломж чадамжийг бий болгоно. Үүрэг амлалт нь иргэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүнд сурталгүй авах нэн таатай орчин бүрдэнэ. <p>•Төр засгийн хариуцлагыг сайжруулах</p> <p>Төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлын хариу мэдээлэл цахим үйлчилгээнд бүртгэгдсэнээр төрийн ямар байгууллага, ямар асуудлаар иргэд, байгууллагын хүсэлтийг цаг хугацаанд нь хариу өгөхгүй байгаа мэдээлэл ил болох тул төрийн хариуцлага сайжирна.</p>
<p>Нэмэлт өгөгдөл мэдээлэл</p>	<ul style="list-style-type: none"> • “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого • Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, чирэгдэлгүй бөгөөд ил тод, нээлттэй үзүүлэх” үндсэн зорилт • Үндэсний хөгжлийн бодлого үндсэн чиглэл, бусад салбарын буюу орон нутгийн хөтөлбөр төлөвлөгөө

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

	[НҮБ-ын] Тогтвортой хөгжлийн зорилтуудад тус тус тусгагдсан болно.	
Хүрэх үр дүнгийн тодорхойлолт	Иргэд, аж ахуйн нэгж төрийн үйлчилгээний талаарх үнэн зөв мэдээллийг хүндрэлгүй, шуурхай авах боломжтой болно.	
Биелэлтийн дараа авах арга хэмжээ/алхамууд	Дараагийн сайжруулалтыг төлөвлөж, иргэд зорилтот бүлгийн үйлчилгээ авах боломжийг илүү нэмэгдүүлнэ.	
Хүрэх үе шатуудын хэрэгжилтийн байдал	Эхлэх огноо:	Дуусгах огноо:
Төрийн үйлчилгээний нэгдсэн систем "eMongolia"-аар үзүүлэх төрийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, илүү хялбар болгох	2021.12.15	2023.06.15
Иргэдээс төрийн үйлчилгээний хүнд суртал, шат дамжлага бусад хүндрэлийн талаар мэдээлэл авах цахим цонхыг "e-Mongolia" системд байршуулах.	2021.12.15	2022.02.15
Хиймэл оюун ухаанд суурилсан технологи ашиглан иргэдэд төрийн үйлчилгээний мэдээлэл, татвар төлөлт, урамшууллын мэдэгдэл хүргэх нэгдсэн платформ хөгжүүлж нэвтрүүлэх.	2022.02.15	2022.05.15
Төрийн үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг тогтмол хангах, тухай бүр шинэчлэх, иргэд, олон нийттэй харилцах төвийн "1111" тусгай дугаараар төрийн байгууллагын хүнд суртал, авлигын шинж чанартай гомдол, мэдээллийг хүлээн авах, хариу өгөх үйл ажиллагааг сайжруулах	2022.05.15	2022.07.15
"1111" тусгай дугаарт ирсэн мэдээлэл, түүнд хариу өгсөн, гомдол барагдуулсан талаарх тайланг сар бүр гаргаж, холбогдох төрийн байгууллагуудад хүргэх, Засгийн	2022.02.15	2023.12.31

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

газрын вэб сайт дээр энэхүү тайлан мэдээллийг байршуулах		
Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн стандарт боловсруулж, батлуулах	2022.07.15	2022.09.15
Арга хэмжээ болгох: том төрөөс ухаалаг төр рүү шилжих улмаар иргэн төвтэй төрийн үйлчилгээг хөгжүүлэх	2022.07.15	2022.09.15
Холбоо барих өгөгдөл мэдээлэл		
Манлайлж хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Засгийн газрын тохируулагч агентлаг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	
Хэрэгжүүлэгч байгууллагын хариуцсан ажилтан	Л.Энхбат	
Албан тушаал, Газар, хэлтсийн нэр	Цахим хөгжлийн газрын дарга	
Цахим шуудангийн хаяг, суурин болон гар утасны дугаар	Enkhbat@cita.gov.mn +(976) 88085764	
Бусад оролцогч талууд	Засгийн газрын яам, агентлаг: Иргэний нийгмийн байгууллага, Хувийн хэвшил, Олон талт байгууллага, Үндэсний хороо, Ажлын хэсэг	ЗГХЭГ, Бүх яамд, АТГ, Төрийн байгууллага, холбогдох бусад байгууллага Тухайн салбарын мэргэшсэн байгууллага, Хувийн хэвшил
Нэмэлт өгөгдөл, мэдээлэл:		

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

	Ч.Болортуяа	Ерөнхий сайдын зөвлөх
	Э.Бат-Идэр	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
	Д.Бямбадулам	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын референт
	Р.Дүүрэнбаяр	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээч
	Б.Булганчимэг	Үндэсний хөгжлийн газрын дэд дарга
	Н.Цэрэнсамбуу	Төрийн худалдан авах ажиллагааны газрын цахим худалдан ажиллагаа, мэдээллийн технологийн хэлтсийн дарга
	Д.Дуламсүрэн	Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга
	Л.Төр-Од	“Транспэрэнси интернэшнл Монгол” ТББ-ын тэргүүн
	А.Баянмөнх	Азийн сан Төрийн бус байгууллагын тэргүүн
	С.Цэндбаатар	Үндсэн уртраг Төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал
	Ч.Доржгүнсмаа	Монголын хувийн хэвшлүүдийн эрүүл мэндийн байгууллага нэгдсэн холбоо ТББ-ын төлөөлөл
	Б.Мөрөнгуа	Бүгд Найрамдахчуудын олон улсын хүрээлэнгийн хөтөлбөрийн ажилтан
	Д.Батзаяа	Эрхэмсэг оршихуй Төрийн бус байгууллагын төлөөлөл
	Г.Ундрал	Ардчиллын боловсрол төвийн захирал
	Баярсайхан	Хил хязгааргүй Төрийн бус байгууллагын төлөөлөл
	Ш.Ариунаа	Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбооны тэргүүн

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-IV
2021-2023 МОНГОЛ УЛС

	Г.Чинзориг	Химийн хаягдлыг бууруулах үндэсний холбооны тэргүүн
	М.Мөнхмандах	Хэвлэлийн хүрээлэн
	А.Оюунчимэг	Иргэний төлөөлөл
	Р.Дуламжав	Иргэний төлөөлөл
	С.Мэндбаяр	Иргэний төлөөлөл
	Д.Эрдэнэчимэг	Нээлттэй нийгэм форум
	Д.Батжаргал	Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбооны тэргүүн
	Г.Ганбат	АТГ-ын дэргэдэх Олон нийтийг зохицуулалтын дарга
	П.Янжинлхам	Монголын нутгийн удирдлагын холбоо ТББ-ын ажлын албаны дарга
	Г.Билэг-Өрнөх	Нутгийн өөрөө удирдах байгууллагын институцын чадавхийг бэхжүүлэх төслийн мэргэжилтэн

--О--